



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.07.05, БААСАН ~ №128 (1180)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Парламентын “хүчирхийлэл”-ээс Засгийн газрыг аврах боломж

Засгийн газар ажил хийхийн төлөө биш “амьд байх”-ын тулд барьцаалагдсаар байх уу. >2

Залуус хөнгөлөлттэй үнээр сувилалд эмчлүүлэх эрхтэй

Өнгөрсөн онд сувилалд эмчлүүлсэн хүмүүст 10.1 тэрбум төгрөг зарцуулжээ. >5

“Торгоны зам” уралдааны үеэр 67 цэгт зам хаана

Гурван орны нутаг дэвсгэрт болох уралдаан 4000 орчим км үргэлжилнэ. >5

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын төрийн тэргүүнд эмгэнэлийн захидал хүргүүлжээ. **Эрхийг нь түдгэлзүүлсэн** шүүгчдээс Б.Цолмонбаатар, Э.Халиунбаяр нарыг цагдан хорив.

Амьд мал хилээр гаргахыг хориглосон тул махны зургаан үйлдвэр нэмж барина.

Цахилгаан станцуудыг 20-иос дээш хоногийн нүүрсний нөөц бүрдүүлэхийг үүрэгдэв.


ЭДИЙН ЗАСАГ

“Аэромонголиа” компани Улаанбаатар-Баянхонгорын чиглэлд нислэг үйлдэж эхэллээ.

“Монголын эдийн засгийн чуулган-2019” ирэх есдүгээр сарын 25, 26-нд болно.

Туркийн инфляцын түвшин зургадугаар сард 15.7 хувьд хүрч, 12 сарын доод цэгт хүрэв.

Топ 20 индекс 0.29 нэгжээр өсөж, 20651.55 нэгжид хүрсэн байна.



НИЙГЭМ

2019 онд 33.9 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй эм олгоход зарцуулна.

Түрээсийн орон сууцны метр/кв-ын үнийг 6000 төгрөгөөр тооцооор болжээ.

“Торгоны зам” авто раллигийн үеэр 67 цэгт ТЦГ-аас хяналт тавьж ажиллана.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг МҮЭХ эсэргүүцэж байна.

ДЭЛХИЙ

Д.Трамп евро, юанийн ханшийг зохиомлоор унагахын эсрэг арга хэмжээ авахаа анхааруулав.

Энэтхэгийн Конгресс намын дарга РГанди сонгуулийн ялагдлын дараа ажлаа өгчээ.

Швейцар улс гадаадынханд өгдөг цалингийн хэмжээгээр дэлхийд нэгдүгээрт бичигдэв.

Boeing ослын хохирогчдод \$100 саяын нөхөн төлбөр санал болгосон байна.

ЦАГ АГААР


УЛААНБААТАР

2019.07.05



24° | 11°

ҮҮЛ БАГАСНА



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Дэлхийн дулаарал жуулчдыг Монгол руу чиглүүлнэ



Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөөс айж суусаар хохирох бус харин байгаль орчин, нийгэм, эдийн засагт ажиглагдаж буй шинэ зүйлийг соргоогоор мэдэрч, тохирсон бодлого хэрэгжүүлж чадвал эрсдэлийг ч өөртөө ашигтайгаар эргүүлж болох нь. ▶ 12

Ж.Гэрэлчулуун / ЗГМ ©

ЗАЛУУС

“Яг түүн шиг” шоуны эхлэл, бас төгсгөлд нь байгаадаа таатай байна

Д.Эрдэнэсүвд

оролцогч билээ. Ингээд жүжигчин, дуучин П.Баярцэнгэлтэй ярилцсанаа хүргэе.

“Яг түүн шиг” шоуны тайзнаа эргэн ирсэн сэтгэгдэл ямар байна вэ?

Universe Best songs 2010 тэмцээнээс од болон гялалзсан дуучин П.Баярцэнгэлтэй яг одоо Holly dolly-г дуулсаар тайзан дээр гэрэлтэж байна. Хоолой нь сөвсөн байгаа нь “Яг түүн шиг” шоуны финалын бэлтгэлтэй холбоотой болов уу. Тэрбээр сайн жүжигчин, өвөрмөц дуучин гэдгийг бид андахгүй. Мөн Монголын ард түмнийг цэнхэр дэлгэцийн өмнө уяж чаддаг “Яг түүн шиг” шоуны анхны шилдэг

▶ 4

ЭДИЙН ЗАСАГ

Япон, Өмнөд Солонгосын маргаан улам хурцадлаа

Жон Херскович

Япон, БНСУ санал зөрөлдөөнөө олон жилийн турш шүүмжлэл, буруутгал, дипломат сануулгаар зохицуулж ирсэн. Гэвч сүүлийн үед АНУ хоёр холбоотныхоо маргаанаас зайгаа барьсан тул эдийн засгийн сөргөлдөөн рүү гулсан орох шинжтэй боллоо. Ерөнхий сайд Шинзо Абэгийн тавьсан экспортын хязгаарлалт пүрэв гарагаас хэрэгжиж эхэлснээр 1910-1945 онд Солонгосын хойгийг колоничилж байсан Японы түрэмгийлэгчид зохих ёсоор уучлал гуйх ёстой

гэдэг асуудал дахин сөхөгдөв.

Абэгийн Засгийн газрын хоригт хагас дамжуулагч болон компьютерийн монитор хийдэг тусгай эд ангиуд багтсан нь үгээр тэмцэлдэх шаг дуусаж, эдийн засгийн өргөн хүрээтэй сөргөлдөөн рүү халтирах эрсдэл үүсгэв. Солонгосын шүүх өнгөрсөн онд Японы Эзэн хааны цэргийн үйлдвэрүүдэд ажиллаж байсан солонгосчууд Японы компаниудаас нөхөн төлбөр авах эрхтэй гэж шийдвэрлэсэн.

▶ 9

ҮЗЭЛ БОДОЛ

Бодлогогүй боловсролын завхрал

Б.Гандолгор

@gandolgorZGM

Танил маань “Надад үр хүүхдэдээ өвлүүлээд байх үнэтэй эд хэрэглэл алга. Тэгэхээр боловсролд нь л илүү анхаарья. Багаас нь сайн багшийн ангид оруулж, толгойд нь жаахан мэдлэг хийгээд өгчихвөл алсдаа сурсан зүйлээрээ хоолоо олж иднэ биз” гэж ярилаа. Түүн шиг эцэг, эх олон. Гэхдээ манай боловсролын чанар эцэг, эхчүүдийн хүсэж буй шиг сайн байгаа эсэх нь эргэлзээтэй. Уг нь суурь боловсролыг нь чанартайхан тавьчихвал хүүхэд аяндаа сурдаг гэж насаараа багшилсан эмэгтэй ярьж суухыг сонсож билээ. Гэтэл сүүлийн үед туршиж буй олон сургалтын хөтөлбөрт эцэг, эхчүүд толгой нь эргэчихээд байгаа. Олон хөтөлбөр туршсанаас болоод боловсролын чанар илт дордсон талаар хэн хүнгүй ярих боллоо. Боловсролын салбарыг толгойлсон сайд бүр дур зоргоороо загнаж, янз бүрийн хөтөлбөр гаргаж туршсаар байтал хэн ч биш хярамцаг болж гүйцлээ.

Ё.Отгонбаяр сайд байхдаа санаачилж хэрэгжүүлэхээр зорьсон “Кембрижийн хөтөлбөр” хөрсөндөө огт буугаагүй. Багш нар хүртэл энэ хөтөлбөрийг монгол хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирдоггүй гэж шүүмжилдэг.

▶ 3

МИАТ ХУВЬЦААТ КОМПАНИ

БЕРЛИН
ШУУД НИСЛЭГИЙН ОНЛАЙН ХЯМД ҮНЭ

Улаанбаатар → Берлин
хоёр талдаа
1'919'600₮

Берлин → Улаанбаатар
нэг талдаа **435EUR**
хоёр талдаа **662EUR**
зөвхөн Баасан гарагийн ОМ33/4 ШУУД НИСЛЭГТ ХАМААРНА

Энэхүү хямд үнийг зөвхөн www.miat.com эсвэл МИАТ application ашиглан худалдан авах боломжтой

App Store | Google Play

АЛТ 1409.55 0.02%	ЗЭС 5,993.00 0.07%	10-ЧИНГИС БОНД 98.700 0.13%	ХУРАЛДАЙ БОНД 110.70 0.12%	ГЭРЭГЭ БОНД 99.330 0.12%	АМ.ДОЛЛАР 2,657.76	ЮАНЬ 387.03	РУБЛЬ 42.13
--------------------------------	---------------------------------	--	---	---------------------------------------	------------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

ТӨСӨЛ

Парламентын “хүчирхийлэл”-ээс Засгийн газрыг аврах боломж

Засгийн газар ажил хийхийн төлөө биш “амьд байх”-ын тулд УИХ-д барьцаалагдсаар байх уу

Б.Энхжаргал
@enkhjirgZGM

1992 оноос хойш 14 Засгийн газар байгуулагдаж, нэг кабинетын дундаж нас 1.8 жил байсан гэдэг статистикаар нийтлэлээ эхэлье.

Хугацаанаасаа өмнө огцорсон Засгийн газруудыг харахад санаачилга хийгээд шийдвэр нь дандаа УИХ дахь олонхоос буюу эрх баригч намаас өөрөөс нь гарч, хэрэгжсэн байдаг. УИХ-ын сонгуулийн дүнгээр олонх болсон нам өөрөө өөрийнхөө болон хамтарч байгуулсан Засгийн газраа дуртай үедээ огцруулж буй нь гүйцэтгэх засаглал хэт сул, УИХ-аас хараат байгаагийн нотолгоо. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн гэж хэлж болохуйц хямрал. Үүнийг л нэн түрүүнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр засахаар өнөөгийн УИХ зорьж байна.

Парламентын засаглалтай орон гэж Засгийн газрын тэргүүнийгээ парламент нь томилдог орныг л хэлдэг. Түүнээс бус парламент нь Засгийн газрынхаа өмнөөс засаглахыг хэлэхгүй. Монгол Улс шиг Засгийн газрынхаа эрх, үүрэг рүү хэт ордог байдал төлөвшсөн парламенттай орнуудад байдаггүй.

Харин манай УИХ-ын гишүүд Үндсэн хууль дахь “Төрийн эрх барих дээд байгууллага нь парламент байна” гэсэн заалтыг ашиглан хэт эрх мэдлийг өөрсөдөө олгож байна.



С.Батсайхан / ЗГМ©

УИХ Ерөнхий сайдыг огцруулсан тохиолдлууд (огцруулах санал өгсөн гишүүдийн тоогоор)

М.Энхсайхан	1998.04.23	Өөрийн саналаар огцорсон
Ц.Элбэгдорж	1998.07.24	39
Ж.Наранцэралт	1999.07.22	42
Ц.Элбэгдорж	2006.01.13	39
Н.Алтанхуяг	2014.11.05	36
Ж.Эрдэнэбат	2017.09.07	42

Ерөнхий сайд болон кабинетынх нь гишүүдийг нэг бүрчлэн томилж, чөлөөлөх эрх УИХ-д бий тул гүйцэтгэх засаглалын эрх мэдэл рүү халдаж, улсын төсвийг дураараа захиран зарцуулаад байна. Зөвхөн өөрт ирэх унацаар улсын ажлыг харж, том төслүүдийг тушдаг популист гишүүд, тэрчлэн Ерөнхийлөгчийн институци Засгийн газрын хөлийг нь тушиж, гарыг нь хүлсээр ирснийг тодотгох хэрэгтэй. Энэ бол зөвхөн өнөөгийн УИХ, Ерөнхийлөгчийн институцид хамаатай үг биш. Зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас хойш Монголын төрийн бодлого энэ “чөтгөрийн тойрог” дунд хий эргэснийг сануулж буй хэрэг.

Монголын улс төрийн намууд дотроо фракцад задардаг өнөөгийн нөхцөлд Засгийн газар УИХ-аас хараат байна гэдэг тэр олон фракцын хүсэл, үзэмж дор л ажиллана гэсэн үг. Үүнийг өнгөрсөн 27 жилийн гүйцэтгэх засаглалын түүх бидэнд харуулж байна. Ажиллах гэхээсээ илүү амьд үлдэхээр тэмцсэн Засгийн газрын эцсийн гарц нь фракцуудын эрх ашгийг хангах, тэдгээрийн төлөөллийг албан тушаалд томилох, төсөв мөнгийг тэдний хяналт дор

хуваарилах байдлаар ажиллах явдал болдог. Ингэснээр Засгийн газар кабинетын зарчмаар ажиллах боломжгүй болж, УИХ-ын тоглоомын байгууллага болсоор байгаа юм.

Харин өнөөдөр парламентын засаглалыг илүү бэхжүүлж, гүйцэтгэх засаглалаа бие даалгах боломжийг олгохоор Үндсэн хуулийг өөрчлөх гэж байгаа нь сайн хэрэг. Юуны түрүүнд төсөлд тусгасан Засгийн газрын бүрэлдэхүүнд Ерөнхий сайдаас гадна дөрвөн гишүүн давхар дээлтэй байж болох заалтыг онцлох. Ингэснээр Ерөнхий сайд болон үндсэн чиг үүргийн яамдын сайд нар УИХ-аас томилогдоно гэсэн үг. Гэхдээ зөвхөн үндсэн чиг үүргийн гэдэг үгээр Үндсэн хуульд суулгачихвал Засгийн газрын бүтэц батлуулахдаа ийм яамаа нэмчихдэг практик манайд бий. Тиймээс Ерөнхий сайдаас гадна дөрвөн сайд хэмээн тооны хязгаар тавьжээ.

Ийм сайд нар УИХ-д байх нь парламент, Засгийн газар хоорондын үндсэн бодлогын ойлголцол дээр чухал үүрэг гүйцэтгэдэг гэж парламентын засаглалтай орнууд үнэлдэг байна.

Нөгөөтэйгүүр УИХ-ын 76

гишүүний 25 хувь нь (өнөөдөрөөр жишээлэхэд) Засгийн газарт ороод суучихаар парламентын үндсэн үүрэг болох хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хяналт тавих ажлаа хийдэггүй. Өөрөөр хэлбэл, засаглалын тэнцвэртэй байдал алдагддаг өнөөгийн гажуудлыг засах боломж нь давхар дээлийг тайлах Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа юм.

Мөн сайд нарыг томилж чөлөөлдөг эрхийг УИХ-аас “хурааж”, Ерөнхий сайдад олгосноор Засгийн газрын тэргүүн биечлэн хариуцлага хүлээдэг болно. Өөрөөр хэлбэл, нэг сайдын алдаа бүхэл бүтэн Засгийн газрын хувь заяаг шийдэх учраас хариуцлага нь асар үнэтэй гэсэн үг. Энэ бол хариуцлагатай байх хамгийн том хөшүүрэг. Ерөнхий сайд

хариуцлагагүй нэгнээр танхимынхаа хувь заяагаа тоглуулахгүйн тулд томилгоогоо ч зөв хийнэ. Ерөнхий сайд танхимынхаа гишүүдийг УИХ, Ерөнхийлөгчид танилцуулж харин томилж, чөлөөлөх, огцруулах эрхийг өөрөө эдэлснээр гүйцэтгэх засаглалын бодлого, хөтөлбөрөө туштай хэрэгжүүлэх, эрх мэдлийн хяналт тэнцлийг сайжруулж, гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагад шилжих нөхцөл бүрдэх юм.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал гурван парламент дамжин яригдаж байна. Гэнэтийн бас шинэ биш энэхүү нэмэлт, өөрчлөлт бараг 30 жил дорой эргэсэн хөгжлийн бодлогыг урагшуулах механизм болох учиртай. Монголын улс төрийн хямралын нөхцөлийг

бүрдүүлээд байгаа засаглалын зааг ялгаагүй байдал, ажил хийхийн оронд “түүнийх долоо минийх долоохон” гэдэг зарчмаар худлаа хийрдэг байдлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр л арилгаж чадна.

Үндсэн хуульд гар хүрэх хувьсгалын тохироо нь олон намын төлөөлөлтэй парламент, эвэсэж байгуулсан Засгийн газартай үед биш нэг нам дангаар эрх барьж буй цагт бүрддэг нь бас үнэн аж. Сонгогчид бүхэл бүтэн 65 суудлыг нэг намд өгсөн нь зүгээр ч нэг тохиолдол биш байх. Энэ хэмжээний дэмжлэг асаван улс төрийн хүчин Үндсэн хуулиа өөрчилж, засаглал хоорондын тэмцлийг зогсоож, дорой хий эргэсэн, дундаа “яс” булаацалдсан, нийгмийн буруу эргүүлгийг засах боломжийг одоо л ашиглах хэрэгтэй. [ЗГМ]

Ерөнхийлөгч

Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгчид эмгэнэл илэрхийлэв

Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Эрхүү мужид их хэмжээний уер болсонтой холбогдуулан тус улсын Төрийн тэргүүн Владимир Владимирович Путинд эмгэнэл илэрхийлсэн захидал илгээлээ.

Захидалд “ОХУ-ын Эрхүү мужид болсон их хэмжээний үерийн улмаас хохирол амссан иргэдэд чин сэтгэлийн эмгэнэл болон сэтгэл санааны дэмжлэг илэрхийлж байгааг хүлээн авна уу. Үүнтэй холбогдуулан Монголын ард түмэн Эрхүү муж дахь үерт автагсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор мөн-

гө, нэн шаардлагатай зүйлс, хоол хүнс, дулаан хувцас хэрэгсэл, эм, эмийн бүтээгдэхүүн цуглуулах хэрэгсэл болно. Мөн Монгол Улсын хүүхдийн амралтын төвүүд Эрхүү мужийн үерт автсан дүүргүүдээс 100 хүртэлх хүүхдийг хүлээн авахад бэлэн байна” гэжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас байгалийн гамшигт өртсөн Эрхүү мужийн иргэдэд туслах уриалга гаргаж, аж ахуйн нэгжүүдээс тусламжийн бараа материал цуглуулах ажлыг үргэлжлүүлж байна.

ЭШЛЭЛ



Нийгмийн бухимдал нь эргээд хоосон улс төржилт хийдэг популистуудад өгөөш болсоор ирлээ. Ямар ч нам ялсан, ямар ч Засгийн газар гарсан нэг бодлоготой түүнийгээ хэрэгжүүлдэг, хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг бол Монгол Улс хөгжинө. Үндсэн хуульд хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн бодлого гэж огт байдаггүй. Иймд бид төслийн 25.1.7-д Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого гэдэг агуулгыг оруулж ирсэн. Үүнтэй холбоотойгоор хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан бүтцийг бий болгох томъёоллол дээр нь ажиллаж байна. Урт хугацааны хөгжлийн бодлогоо Засгийн газар, улс төрийн намаас үл хамааран УИХ-аар тодорхойлж, батлуулан Засгийн газар хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх гэсэн.


УИХ-ын гишүүн С.Бямбацогт

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» INFO@ZAS.AG

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН АНХААРАЛД

Худалдаа, хөгжлийн банк (ХХБанк)-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 10.00 цагт, Монгол Улс, Улаанбаатар-14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны хурлын танхимд хуралдана.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал:

1. Банкны дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
2. ТУЗ-ийн ердийн гишүүнийг чөлөөлж, томилох тухай;
3. Бусад асуудал.

2019.07.05

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбатын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Энхтайваны өргөн чөлөө, “Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
[ubinfo.mn](mailto:ubinfo@mn)
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан



8638000429112 01179

Үзэл бодол

Боловсролын салбар үе үеийн сайдуудын тоглоомын талбар байх ёсгүй

Зарим нэг багшийн хэлж буй нь Барууны боловсролын систем Монголд тийм ч сайн тохирохгүй. Манай монгол хүүхдүүдэд ёс суртахууны хүмүүжил хэрэгтэй. Барууны боловсролын хэв маяг бол нэлээд задгай, нээлттэй, хүүхдийн эрх ашгийг дээдэлсэн байдаг. Тэгэхээр “Кембриж” бол төдийлэн нийцэхгүй хөтөлбөр шиг санагддаг хэмээсэн юм.

БАГА АНГИЙНХНЫ ЦҮНХТЭЙ АЧАА ХӨНГӨРӨХ ҮҮ

Одоо явж буй “Цөм” хөтөлбөр хэдийгээр агуулга сайтай болсон ч сурах бичгийн алдаа мадаг нь тамтаггүй гээд өөлөх зүйл гарч ирсээр. Түүхийн хичээлийн агуулга ч бүр түүхийрч гүйцэж. Элсэлтийн шалгалтад түүхийн хичээлээр шалгалт өгсөн хүүхдүүдийн нь бүдэрсэн тухай хэн хүнгүй ярьж байна.

“Цөм” хөтөлбөр хэрэгжүүлс-



Дэлхий нийтэд манай боловсролын чанарын үнэлгээ ямар түвшинд байдаг талаар интернэт ухаж сонирхлоо. Олон улсын боловсролын мэдээллийн сангийн судалгаагаар 200 орноос 81 дүгээр бичигджээ. Эхний байрт Өмнөд Солонгос, араас нь Финланд, гуравдугаарт Норвеги, дөрөвт ОХУ оржээ.

С.Батсайхан / ЗГМӨ

Бодлогогүй боловсролын завхрал

нээр бага ангийнхан цүнхээ даахаа байсан. Багаас нь даахааргүй хүнд ачаа үүрүүлж, мэдлэгээр бөмбөгдсөөр байтал мэдэрлийн ядаргаанд орж дууслаа. Хичээл дээрээ баахан юм судлахын хажуугаар элдэв төрлийн дугуйлан, сонгон гээд насандаа ахадсан ачаа үүрээд зарим хүүхэд залхдаг бололтой юм билээ. Нэг ёсондоо энэ хөтөлбөр бол Японы боловсролын системээс хуулбарласан хэлбэр. Багш нар “Цөм” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсний дараа ямар сурах бичиг хэрэглэхээ мэдэхгүй хэсэгтээ л мунгинасан. Хөтөлбөртөө тохирсон агуулгатай сурах бичгээ боловсруулж, хэвлэж амжаагүй болохоор бид хүүхдүүдийнхээ

зорилгоо салбарын яам нь тодорхойлодоггүйн гайгаар хүүхдүүд хэлмэгдэж байна.

Ер нь манай боловсролын систем яг хаашаа яваад байгааг ойлгох юм алга. Хэтэрхий мэдлэгээр бөмбөгдөөд суурь хүмүүжил, ёс суртахуунд нь анхаарахаа байлаа. Эцэг, эх бидний ойлголтоор сургууль бол хүүхдийг бүрэн төлөвшүүлэх үүрэгтэй газар байх учиртай. Боловсролын салбарын бодлого ийм маягаар явбал алс хэтдээ хүмүүжлийн доголдолтой нөхдүүдээр энэ улс дүүрч мэдэх нөхцөл байдал үүссэн. Гэхдээ энэ байдлыг одоогийн сайд Ё.Баатарбилэг засаж залруулахаа амлаад байгаа.

“Цөм” хөтөлбөрийг цөмлөнө гэж сайд болмогцоо ам алдсан нь олны анхаарлыг татсан. Энэ амлалт хэрэгжиж, багачуудын ачаа бага зэрэг хөнгөрвөл ядаж нурууны өвчин тусахгүй байх. Нэг жил хүрэхтэй үгүйтэй

● **Хэтэрхий мэдлэгээр бөмбөгдөөд суурь хүмүүжил, ёс суртахуунд нь анхаарахаа байлаа.**

● **Боловсролын чанарын үнэлгээгээр Өмнөд Солонгос эхний байрт араас нь Финланд, гуравдугаарт Норвеги, дөрөвт ОХУ оржээ.**

● **Сайн гэсэн хөтөлбөр бүрийг хуулсаар байтал эцэстээ боловсролын ямар системтэй улс вэ гэдэг нь ойлгомжгүй боллоо.**

хугацаа үлдсэн энэ үед олон ажил хийж, алдаа дутагдлыг нь засаж залруулна гэдэг амаргүй. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно гэгч болж бүр дордуулчихаж мэдэх юм. Багш нартай уулзахаар Финландын боловсрол чанараараа дэлхийд дээгүүрт ордог. Энэ улсын боловсролыг нутагшуулж болох эсэх талаар судалж байгааг хэлж байсан. Сайн гэсэн хөтөлбөр бүрийг хуулсаар байтал эцэстээ боловсролын ямар системтэй улс вэ гэдэг нь ойлгомжгүй болж байгаа юм.

200 ОРНООС 81 ДҮГЭЭРТ БИЧИГДСЭН БОЛОВСРОЛЫН ЧАНАР

Элсэлтийн шалгалтад хамгийн бага оноо авсан нөхдүүдийг багшийн сургуульд оруулчихдаг байсан нь олон нийтийн шүүмжлэлд өртөж, арай дөнгүүр хүмүүсийг элсүүлэхээр болсон нь саяхны шийдвэр. Тэгэхээр

өнөө бага оноотой багшийн сургуульд элсэж байсан нөхдүүд одоо бидний хүүхдэд хичээл зааж байгаа гэсэн үг. Багшийн эрдэм шавиас гэж зүгээр ч нэг хэлсэн үг биш. Багш нь мундаг байж л хүүхэд нь мэдлэг чадвартай иргэн болох ёстой. Гэтэл зарим багшийн мэдлэг, заах арга барил дулимагхан байдаг нь нууц биш.

Өнгөрсөн сард улс даяар элсэлтийн шалгалт болж, эцсийн дүн гарлаа. Энэ эцсийн дүнгээс сургалтын чанар, чансаа ямар байгаа нь харагддаг. Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн хэлэхдээ “Сурлагын чанар өнгөрсөн жилийн жишиг л байлаа” гэж бөөрөнхийлөв. Тэгэхээр яг тодорхой үнэлэлт өгч чадахгүй байна. Дэлхий нийтэд манай боловсролын чанарын үнэлгээ ямар түвшинд байдаг талаар интернэт ухаж сонирхлоо. Олон улсын боловсролын мэдээллийн сангийн судалгаагаар 200 орноос 81 дүгээрт бичигджээ.

Эхний байрт Өмнөд Солонгос, араас нь Финланд, гуравдугаарт Норвеги, дөрөвт ОХУ оржээ. Монголчуудын хуучин нийгмийн үед мөрдөж байсан хойд хөршийн боловсролын систем тэгэхээр муугүй байсан нь энэхүү жагсаалтаас харагдаж байна.

Мэдээж цаг үеэ дагаад сургалтын хөтөлбөр, агуулгаа өөрчилсөн ч нэг дор ааг амьсгаагүй зүтгээгүйг орос сургуульд нэлээд гэдэн жил багшилсан эмэгтэй ярьж байв. Хойд хөрш 11 жилийн боловсролын систем рүү алгуур шилжсэн хэдий ч тухайн хүүхдэд хүнд ачаа үүрүүлдэггүй аж. Багш хүүхэд бүртэй тулж ажилладаг бөгөөд чөлөөтэй, нээлттэй болгоход их анхаардаг юм байна. Анги бүрийн хүүхдийн тоог тогтоосон стандартаар нь мөрддөг агаад хүн болгож төлөвшүүлэх ёстой гэсэн хатуу зарчим баримталдаг. Орос школыг манай боловсрол яаж гүйцэх юм бэ хэмээн сэтгэл дундуур өгүүлсэн. Манайх шиг нэг ангид 50 хүүхэд чихэж суулгачихаад багш нь самбарын өмнө бархираад байж байдаггүй л юм байна.

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО БА БҮХЭЛ МАХ

Манай боловсролын салбарт долоо хэмжиж нэг огтолсон 20, 30 жилийн системтэй бодлого хэрэгтэй байна. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого гэж 2014-2024 он хүртэл хэрэгжүүлэх ёстой баримт бичиг бий. Энэ баримт бичигт багш ямар байх вэ, сургалтын агуулга нь ямар байх, анги дүүргэлт, хүүхдийн суурь хүмүүжлийг хэрхэн төлөвшүүлэх талаар ерөнхийд нь ганц өгүүлдээр тусгачихсан болохоос стандарт, нарийн шалгуур үзүүлэлтийн талаар тодорхой оруулж өгсөнгүй. Тухайлбал, тус баримт бичгийн 1.2-т Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго нь иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино гэсэн байгаа юм.

Ийм хүмүүжилтэй, ийм бие хүн болгож төлөвшүүлэх ёстой гэсэн нарийн тодорхой заалт байхгүй. Нэг ёсондоо бүхэл мах шиг л юм болж дээ. Эмх цэгцтэй, алсын хараатай хүнийг хүн болгож төлөвшүүлэх бодлого энэ салбарт үгүйлэгдэж байна. Бас багш бэлтгэхдээ тодорхой бодлого барих хэрэгтэй болов уу. [ЗГМ]

Залуус

П.Баярцэнгэл: “Яг түүн шиг” шоуны эхлэл, бас төгсгөлд нь байгаадаа таатай байна

**Өөртөө итгэлтэй гэхээс
илүүтэй бүтээх гэж буй
дүрээ сайн гаргахыг маш их
хичээж байна**

◀1

Хөгжилтэй, дурсамжтай түүхийн нэг хэсэг болсондоо үнэхээр их баярлаж байна.

-Тэгвэл хувирахад хамгийн хэцүү дүр аль нь байв?

-Ер нь бүх л дүр амаргүй байсан. Анхны шоунд сүүлийн шатны Бруно Марсын ялагч болдог үзүүлбэр маш хэцүү байсан. Харин энэ шоунд Лэди Гагаг дуурайх амаргүй байлаа. Бүжгийн бэлтгэлээс авахуулаад дуулалт гэх мэт зүйлс хүндрэлтэй байсан.

-Та Бруно Марсыг дуурайгаад ялагч болсон. Мөн энэ улиралд Лэди Гагагийн Always remember us this way дуугаар түрүүлсэн гэхээр хэцүү хүнд байх тусам танд ээлтэй байдаг юм биш үү?

-Бэлтгэл их хийж, маш их хичээсэн болохоор тэр юм болов уу (инээв).

-Энэ жилийн шоу анхныхаас юугаараа ялгаатай байна вэ?

-Энэ жилийн шоунд өмнө нь 10 дугаарыг давж ялагч болсон шилдгүүд оролцож байгаагаараа онцлог. Туршлагатай хүмүүс байгаа болохоор илүү үзүүштэй, өрсөлдөөнтэй, чанартай сайхан болсон болов уу. Мөн Боловсрол телевиз шоунд анхаарлаа сайн хандуулсан байна лээ. Тайз засал, цаашлаад хамт ажиллаж буй багийн хувьд ч тэр бүх зүйл нь илүү шинэлэг болсон байна.

-Бруно Марсаар гайхшируулж байсан үе саяхан санагдаж байна. Финалын бэлтгэл хангагдсан уу. Өөртөө хэр итгэлтэй байна вэ?

-Бэлтгэл дажгүй ээ. Финалын бэлтгэлээс болоод хоолой сөөчихөөд явж байна даа. Өөртөө итгэлтэй гэхээс илүүтэй бүтээх гэж буй дүрээ сайн гаргахыг маш их хичээж байна. Үзэгчдэдээ финал дээр гэнэтийн бэлэг барина аа.

-Шоугаа дуусгаад уран бүтээлдээ орох уу?

-Одоо ч гэсэн уран бүтээлдээ анхаарал хандуулж байна.

-Ёодлоо хэзээ ч орхихгүй гэж байсан. Ёодлоороо уран бүтээл хийж байгаа юу?

-Одоогоор барьж авсан уран бүтээл алга. Ерөнхийдөө ярьж тохирсон зүйлүүд бий. Хийж дуусгаад л мэдэгдэнэ дээ.

-Та ёодлыг цаашид хөгжүүлэхийн тулд багшлах бодол бий юу?

-Ёодлын фестивальд явахад 10 мянга орчим хүн оролцсон. Дийлэнх нь европчууд байна лээ. Ер нь Азид ёодлын хөгжил муу. Тэр дундаа Монголд энэ төрөл огт хөгжөөгүй. Тиймээс сурья гээд ирсэн хүнийг түлхэхгүй ээ. Гэхдээ онол талаас нь зааж чадахгүй байх. Учир нь би өөрөө

youtube багштай, сонсголоороо сурсан хүн шүү дээ.

-Цөөнгүй кинонд тоглоод амжсаныг мэдэх юм. Уран сайхны кинонд хэчнээн дүр бүтээгээд байна вэ. Өөртэйгөө төстэй дүрд тоглож байв уу?

-Яг тоолж байгаагүй юм байна. Анх 2011 онд “Аз жаргалын эрэлд” гэдэг кинонд тоглож байлаа. Надад ихэвчлэн хөгжилтэй талын дүр оногддог юм. Энэ нь амьдрал дээр зохиолынхоо баатартай төстэй шинж юм уу даа. Ерөнхийдөө найруулагч хүн зохиолоо уншихаад баатартай нь тохирох хүнийг сонгодог учраас бүх дүрд төстэй тал бий.

-Та дуулах авьяасаа аав, ээжээсээ өвлөж авсан гэж ярилцлагадаа өгүүлж байсан. Харин таны авьяасыг хүүхдүүд тань өвлөж авсан уу?

-Одоогоор айхтар мэдэгдсэн юм алга. Гэхдээ дуу хуурт их дуртай. Саяхан манай хоёр морин хуур нэхээр байгаад авахуулсан. Хоёулаа бие биедээ таарсан жижиг морин хууртай болсон. Хэрэв өөрсдөө сонирхоод байвал цаашдаа хөгжүүлнэ гэж бодож байгаа.

-Та хүүхдүүдээ ёдол зааж өгөх гэж оролдож байв уу.

Ер нь гэр бүлдээ хэр их цаг зарцуулдаг вэ?

-Оролдож байгаагүй. Гэр бүлдээ бол цаг сайн зарцуулдаг. Шоуны бэлтгэл гээд зав муутай байгаа ч гэр бүлдээ зарцуулах цагаасаа хумслахгүй ээ.

-Хэзээ ч санаанаас гардаггүй, сэтгэлд хоногшсон бага насны дурсамжаасаа хуваалцвал?

-Манай аав Пүрэвсүрэн гэж соёлын тэргүүний ажилтан, дуучин хүн байдаг юм. Сүхбаатарын соёлын ордон гэж байхад гавьяат Ш.Чимидцэеэ гуай аавтай хамт ажилладаг байлаа. Би таван настай байсан юм. Тэр үед манай жаазанд Ш.Чимидцэеэ гуайн аавтай авахуулсан залуугийн зураг нь байдаг байв. Нэг өдөр би тэр зургийг ширтгээд их уджээ. Аав анзаарчихаад “Миний хүү юу харсан юм” гэсэн чинь “Гүй ээ мөн сайхан хүүхэн юм аа” гэсэн гэдэг. Аав ээж хоёр одоо хүртэл үүнийг ярьж шоолдог юм.

-Та багадаа ямар хүүхэд байв. Ямар хичээлд дуртай байсан бэ?



С.Батсайхан / ЗГМӨ

● Шоуны бэлтгэл гээд зав муутай байгаа ч гэр бүлдээ зарцуулах цагаасаа хумслахгүй ээ.

● Энэ удаагийн шоунд Лэди Гагаг дуурайх хамгийн хэцүү байлаа.

● Нэгэн үеийн уран бүтээлчид оролцож түүх бүтээж буй шоу. Хөгжилтэй, дурсамжтай түүхийн нэг хэсэг болсондоо үнэхээр их баярлаж байна.

-Мэдээ орсон цагаасаа л дуу хуур, урлаг, уран сайхан, хөгжимд өлгийдүүлсэн. Тиймдээ ч хичээл номонд нэг их дуртай биш. Зохиолын дуу сонсох дуртай. Тэр дундаа дуучин Ч.Баг-Эрдэнэ, С.Жавхлангийн дууг их сонсодог хүүхэд байлаа. Урлагийг хайрладаг, хүндэлдэг байсан, одоо ч хэвээрээ.

-Та урлагт ийм их хайртай мөртлөө яагаад дуучин биш жүжигчний мэргэжлийг сонгосон бэ?

-Одоо би хоёуланг нь хослуулж байна. Энэ л миний харсан ирээдүй юм даа. Дуучин хүмүүс ихэвчлэн дуулна, бүжиглэнэ, жүжиглэнэ олон талын авьяастай байдаг. Тиймээс тал бүрийн авьяасаа хөгжүүлэх хэрэгтэй юм байна, жүжигчний мэргэжил эзэмших хэрэгтэй гэдэг үүднээс 2007 онд Д.Жигжидийн нэрэмжит Кино урлагийн дээд сургуульд элсэж, 2011 онд төгссөн. Үндсэн мэргэжлээсээ гадна дуулалтаа хөгжүүлж эхэлсэн. Залуу хүмүүс

өөрийгөө хөгжүүлж л байх хэрэгтэй.

-Хамгийн анхны бүтээлээ хийчихээд өөрөө үзэхэд ямар сэтгэгдэл төрж байв?

-Сайн санахгүй байна. Гэхдээ их л ичиж байсан болов уу. Яагаад гэвэл тэр үед мөнгө багатай болохоор энд тэндээс гуйж түүж байгаад чанар муутай бүтээл хийж билээ. Үүнээс илүү гоё хийсэн бол гэсэн бодол төрж байсан шүү.

-Танд үлгэр дуурайл авдаг урлагийн хүн бий юу?

-Дэлхийн болоод Монголын үе үеийн шилдэг дуучид, жүжигчдийг хүндлэлгүй яахав. Тэр дундаа Жеки Чаныг хамгийн ихээр хүндэлдэг. Тэр хүн бол агуу жүжигчин, мөн мундаг тамирчин. Зургаан хэлээр ярьдаг, муугүй мэдлэгтэй хүн. Хамгийн гол нь хөдөлмөрч, тэвчээртэй. Олон удаа ясаа хугалж байсан мөртлөө хэзээ ч шантарч кино урлагийг орхиогүй. Түүний авьяас, хөдөлмөр, тэвчээрийг хүндлэхгүй байхын аргагүй. [ЗГМӨ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн монгол талын хөрөнгө, “Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл” нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: ЭМЯ-19/003-д

Эрүүл мэндийн яам нь эрх бүхий тендер оролцогчдоос Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн монгол талын хөрөнгө, “Тоног төхөөрөмж” Дугаар: ЭМЯ-19/003-д **нийлүүлэх** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх **стой**. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2016, 2017, 2018 он)-ийн дундаж борлуулалтын хэмжээ нь тухайн багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тухайн багцын төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил (2016, 2017, 2018 он).

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд тухайн багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй нэг удаагийн гэрээгээр нийлүүлсэн байх. (Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн

актын хуулбарыг ирүүлнэ).

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.

Нийт дүн: 17,901,500.0 /Арван долоон сая есөн зуун нэг мянга таван зуу/ төгрөг

Багц-3: Эмнэлгийн тоног төхөөрөмжүүд-9,569,000 /есөн сая таван зуун жаран есөн мянга/ төгрөг
Багц-4: Эмнэлгийн бусад багаж, хэрэгсэл-8,332,500 /найман сая гурван зуун гучин хоёр мянга таван зуу/ төгрөг

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хүчинтэй байна

Цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар гаргуулна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендер оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө.

Тендерийг: 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн 09 цаг 30 минутад** Эрүүл мэндийн яамны хурлын 215 тоот танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Хонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх цагаар авч болно.

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14210, Монгол Улс, Эрүүл мэндийн яам, Хөрөнгө оруулалтын хэлтэс. Утас: 51-263631

Нийгэм

Залуус хөнгөлөлттэй үнээр сувилалд эмчлүүлэх эрхтэй

Өнгөрсөн онд 91,400 хүн рашаан сувилалд хэвтэн эмчлүүлжээ.



С.Батсайхан / ЗГМФ

Сувилуулах шаардлагатай гэсэн эмчийн бичиг хөнгөлөлт эдлэх гол "тасалбар" юм

Г.Санжааханд
@sanjaakhandZGM

Урин дулаан зун цаг ирэхтэй зэрэгцэн амралт, сувиллын газрыг зорих урсгал нэмэгддэг. Гэхдээ сувиллын газраар зөвхөн ахмадууд л үйлчлүүлэх эрхтэй гэсэн нийтлэг ойлголт бий. Тэгвэл эрүүл мэндийн даатгалаа ашиглан нас харгалзахгүйгээр хөнгөлөлттэй үнээр рашаан сувилалд явах эрхтэй гэдгийг та мэдэх үү.

Эрүүл мэндийн даатгал төлдөг л бол хэдэн ч удаа сувилалд хэвтэн эмчлүүлэх боломжтой болохыг албаны хүмүүс хэлж байна. “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн даатгуулагч ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг хариуцдаг тусламж, үйлчилгээг өөрийн эрэлт хэрэгцээнд тохируулан авах боломжтой. Тиймээс рашаан

сувиллын тусламж үйлчилгээг авах эрх нь бүрэн нээлттэй. Зөвхөн ахмад настнууд амарна гэсэн журам байхгүй учраас нас харгалзахгүй гэсэн үг. Тухайн даатгуулагч даатгалын гэрээтэй эмнэлэг, рашаан сувилал, эмийн сангаар дамжуулан үйлчилгээ авах боломж нь нээлттэй” хэмээн ЭМДЕГ-ын Бодлогын хэрэгжилтэн газрын ахлах мэргэжилтэн Н.Хишигсүрэн ярилаа.

Сувилалд хэвтэн эмчлүүлэх гэж буй хүмүүс нэн түрүүнд аймаг, дүүргийнхээ нэгдсэн эмнэлгийн эмчээр “сувилуулах шаардлагатай” гэсэн илгээх бичиг авах ёстой. “Эмчийн заалтаар зайлшгүй шаардлагатай гэсэн тохиолдолд л хэвтэн эмчлүүлнэ” гэдгийг ахлах мэргэжилтэн Н.Хишигсүрэн онцлон сануулж байлаа. Учир нь рашаан сувилалд сувилуулах боломжгүй эсрэг заалт гэж байдаг аж. Тодруулбал, хэт өндөр даралттай, амьсгал болон зүрх судасны дутагдалтай юм уу, хавдартай хүмүүс сувилалд явж болохгүй. Иймээс заавал мэргэжлийн эмчид үзүүлээд “Рашаан сувилалд явж болно” гэсэн тодорхойлолт авах нь хөнгөлөлт эдлэх гол “тасалбар” болох юм.


ЭМД-ЫН САНГААС 110 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛДЭГ

Нэг сувиллын ор хоногийн төлбөр 40 мянган төгрөг байлаа гэж бодоход, долоо хоног сувилуулахад 280 мянган төгрөг төлөх шаардлагатай болно.

Өнгөрсөн онд сувилалд эмчлүүлсэн хүмүүст 10.1 тэрбум төгрөг зарцуулжээ

Үүнээс 110 мянган төгрөгийг нь хасуулаад үлдсэн мөнгөө өөрөө төлөх зарчмаар энэхүү хөнгөлөлт хэрэгждэг. Тиймээс сувилуудын ор хоногийн төлбөрөөс хамааран даатгуулагчийн төлөх мөнгө харилцан адилгүй байх юм.

Өнгөрсөн онд 91,400 хүн рашаан сувилалд хэвтэн эмчлүүлсэн бөгөөд ЭМД-ын сангаас 10.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Хөнгөлөлт эдлэсэн хүмүүсийн нас, хүйсийн талаарх дэлгэрэнгүй



тайланг нарийвчлан гаргадаггүй болохыг албаны хүмүүс хэлж байсан юм. Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар 3.8 тэрбум төгрөг зарцуулаад байгаа аж.

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалаа сар бүр төлснөөр ЭМД-ын сангаас 16 төрлийн үйлчилгээ авах эрх үүснэ. Үүн дотор рашаан сувиллын үйлчилгээ багтдаг. Энэхүү үйлчилгээ нь дотроо 10 гаруй төрөл байдаг аж. Тодруулбал, рашаан уух, рашаанд орох, шавших, шавар эмчилгээ, халуун шавар, хүйтэн шавар элсний үйлчилгээ, бариа засал, сэргээн засах, зүү төөнүүр, уламжлалт гэх мэт эмчилгээ бий. Зөвхөн рашаан сувилалд амарч

байгаа иргэдийн хувьд эдгээр үйлчилгээг авах боломжтой. Тиймээс иргэд эрүүл мэндийн байдлаасаа шалтгаалж сэргээн засах сувилалд хэвтэх, рашаан эмчилгээ хийлгэх, эсвэл шавар эмчилгээнд явах эсэхээ сонгон үйлчлүүлэх юм байна.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд нийт 50 гаруй рашаан сувиллын газар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллаж байна. Үүний 29 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр газрын нэр, хаяг болон холбоо барих хэсгүүдэд хэсэгчлэн хаана. Орон цахим сайтаас (www.emd.gov.mn) авах боломжтой. [ЗГМ]

мэдээ мэдээлэл

Хөшигийн хөндийн нисэх буудал ашиглалтад орох болоогүй

Б.Бадамцэцэг
ЗГМ

“Хөшигийн хөндийн онгоцны буудал албан ёсоор нээлтээ хийнэ” гэсэн мэдээлэл зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр гараад байна. Энэ талаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн захиргааны мэргэжилтэн Б.Намуунаас тодрууллаа. Тэрбээр “Улаанбаатар хотын Олон улсын

нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг “хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх” нөхцөлөөр Монгол, Японы хамтарсан компанитай концессын гэрээг өнөөдөр байгуулж байгаа юм. Менежментийг эхлүүлж байгаа гэдэг нь нислэг үйлдэж, албан ёсоор ашиглалтад орж байна гэсэн үг биш. Албан ёсны нээлт болно гэсэн ташаа мэдээлэл гарсан байна. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, Японы талаас “Консорциум SPV” буюу



“Жапан Эйрпорт Менежмент” ХХК төслийг хэрэгжүүлэхээр болсон. Концессын хугацаа 15

жил бөгөөд концесс эзэмшигчид гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дотор өөрийн

хөрөнгөөр бэлтгэл ажлаа ханган нисэх буудлын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн” гэсэн юм. [ЗГМ]

Саарал усыг авто угаалгад ашиглахыг зөвлөв

Б.Өлзий
ЗГМ

Нийслэлийн байгаль орчны газраас 90 гаруй авто угаалгын газрын төлөөлөлд саарал усны стандартыг нэвтрүүлэх, нэвтрүүлсэн газруудын туршлага хуваалцах сургалтыг зохион байгууллаа.

Нэг автомашиныг угаахад дунджаар 40-50 литр цэвэр ус ашигладаг байна. Иймд сургалтын хүрээнд саарал ус ашигласнаар цэвэр ус ашигласан төлбөрөөс хөнгөлөгдөх боломжуудыг онцоллоо.

Үүнд М-Си-Эс Кока Кола компанийн ашигласан саарал усыг зөөврийн байдлаар авч ашиглах болон аж ахуйн нэгжүүд технологийг нэвтрүүлэх боломжууд багтах аж. Гэвч түрээсийн авто угаалгын газрууд саарал усны тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамаарч суурилуулахад 10 сая төгрөгөөс дээш өртөгтэй гарчээ. Иймд зээлийн хэлбэрээр технологийг суурьшуулах боломжтой ч стандартын шийдэл гараагүй байгаа аж ахуйн нэгжүүд учирлаж байв. [ЗГМ]

“Торгоны зам” уралдааны үеэр 67 цэгт зам хаана

Б.Бадам
ЗГМ

“Торгоны зам” автомашин, мотоциклын холын зайн ралли энэ сарын 6-16-ны өдрүүдэд ОХУ-Монгол-БНХАУ-ыг дамнан зохион байгуулагдах гэж байна. Гурван орны нутаг дэвсгэрт болох уралдаан 4000 орчим км үргэлжилнэ. Энэ удаагийн уралдаанд 500 орчим техник хэрэгсэлтэй 43 орны тамирчин оролцоно. Мөн хэвлэл мэдээлэл, үйлчилгээний ажилтан, үзэгч сонирхогч нийлээд 3000 гаруй хүн оролцох мэдүүлэг өгчээ.

Энэ үеэр замын хөдөлгөөнийг хэрхэн зохицуулах талаар

Тээврийн цагдаагийн албаны ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Т.Ганзоригоос тодрууллаа. Тэрбээр “Торгоны зам олон улсын авто ралли уралдаан нь Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн хилийн боомтоос Өмнөговь аймгийн Гашуунсухайтын хилийн боомт хүртэл таван аймгаар дамжин, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохицуулалт, хамгаалалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Уралдаан дайран өнгөрөх 9-13-

ны өдрүүдэд манай Тээврийн цагдаагийн албанаас 113 албан хаагч, 30 тээврийн хэрэгсэлтэйгээр 67 цэгт хяналт тавин ажиллана. Замыг бүрэн хаахгүй, уралдаан дайран өнгөрөх хэсгүүдэд хэсэгчлэн хаана. Орон нутгийн замд тодорхой хуваарийн дагуу тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг түр хязгаарлах ба уралдаан явагдаж буй замын орчимд аль болох хөдөлгөөн үйлдэхгүй байх, замын ойролцоо малаа хариулаггүй орхих, гэр, майхан барихгүй байх, уралдааны аюулгүй байдлыг хангаж буй алба хаагчдын шаардлагыг биелүүлэхийг иргэд, олон нийтээс хүсч байна” гэсэн юм. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ГЭМТ ХЭРЭГ

Бага насны хүүхэд хүчиндсэн этгээдүүдэд 14, 15 жилийн хорих ял онолоо.

» ЭКОЛОГИ

Олон улсын эко соёлын аян энэ сарын 5-18-ны хооронд Улаанбаатар хот, Орхон аймаг, Хөвсгөл аймгийн Мөрөн, Хатгал суманд болно.

» ЗОХИЦУУЛАЛТ

2500

Наадмын үеэр “Хүй долоон худаг”-т цагдаа, цэрэг, мэргэжлийн хяналт зэрэг нийлсэн 2500 гаруй төрийн албан хаагч ажиллана.

» ШИЙДВЭР

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр зургаан аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв” байгуулна.

» ЭРҮҮЛ МЭНД

5

Тэрбум төгрөг. Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдийн зонхилон хэрэглэдэг эмийн үнийг 80 хүртэл хувиар хөнгөлж, хөнгөлөлттэй эмэнд зарцуулах төсвийг таван тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

» СОЁЛ УРЛАГ

Чойжин ламын сүм музей Монгол Улсын Филармонийн Баянмонгол чуулгатай хамтран “Үдшийн музейд-Жазз” тоглолтыг энэ сарын 8-нд 20:00 цагаас зохион байгуулна.

» ОРОН НУТАГ

Булган аймгийн Тэшиг суманд хөрш орны ард түмний “Эв мод”, буриад зоны “Бага алтаргана” наадам боллоо.

» СЭРЭМЖЛҮҮЛЭГ

5.9

Тэрбум төгрөг. Он гарсаар улсын хэмжээнд эхний зургаан сард 2561 удаагийн ахуйн гал түймэр гарч, 5.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 37 хүн амиа алдаж, 985 гэр, орон сууц шатжээ.

» НИЙГМИЙН ДААТГАЛ

3.4

Тэрбум төгрөг. Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгож эхэллээ. Энэ жил 12,449 даатгуулагчид 3.4 тэрбум төгрөгийг буцаан олгох юм.

» БУЦААН ОЛГОЛТ

Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгож эхэллээ. Энэ жилийн тухайд 12449 даатгуулагчид 3.4 тэрбум төгрөгийг буцаан олгох юм байна.

» АРГА ХЭМЖЭЭ

“Дээлтэй Монгол наадам” арга хэмжээг энэ сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 13 дахь жилдээ зохион байгуулна.


» ХАНДИВ

“Өргөө” амаржих газарт 150 сая төгрөгийн үнэ бүхий автотөхөөр буюу ариутгалын аппаратыг хүлээлгэн өглөө.

» ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 29 байгууллагын 30 салбар нэгжид НМХГ-аас төлөвлөгөөт хяналт шалгалт хийжээ. Шалгалтаар 11 байгууллагын 14 рентген аппаратыг ашиглалтын үйл ажиллагааг түр болон хэсэгчлэн зогсоосон байна.

Сурталчилгаа



Зуны ангиуддаа элсэлт авч байна

77118288

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь “Цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах” /Сүхбаатар дүүрэг, 15 хороо/ зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ **НХААГ-19/012 дугаартай** болно.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

3.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн баталгаажуулсан хуулбар

3.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт

Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт

Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.

Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрөө төлсөн байна. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

Ижил төстэй ажлыг хамгийн багадаа нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн байна. Сүүлийн 2 жил (2017, 2018 он) гүйцэтгэсэн ажлын гэрээ, актыг хавсаргана.

Голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.

Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эхээс баталгаажуулж ирүүлэх

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яам

1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зураг төсөл

1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10кВ хүртэл), дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл, орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

1.2.6 Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв эсвэл;

ЗТ-3.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл

ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

ЗТ-11.2 Барилга байгууламжийн ажлын төсөв

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 11:00 цаг** хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр мэдүүлгээ **2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 11:00 цагийн дотор** ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцаа холбооны тоон технологийн тоног төхөөрөмжийн сайжруулах тендерийн баримт бичиг

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/110

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцаа холбооны тоон технологийн тоног төхөөрөмжийн сайжруулах тухай цахим** тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын борлуулалтын дундаж орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг үндсэн гүйцэтгэгчээр нийлүүлсэн байх.

Ижил төстэй ажилд тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Үгүй

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. 1,200,000 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөг

Тендерийг **2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 13 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 13 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар
давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

ZGM DAILY

Naadam Festival to re-occur in English

Tourists to receive 3500 seats of the Naadam Festival.

Mongolia bans exports of living livestock

Mongolia has more than 66.46 million live-stock animals.

Resolution to establish the Museum of Chinggis Khaan passes

Officials discuss on temporarily combining the other two museums.

Top 20 index up 0.29 percent to 20,651.55

Market cap stands at MNT 2,58 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS


The Cabinet passes a resolution to establish the Museum of Chinggis Khaan and to temporarily combine the Natural History Museum with the Central Museum of Mongolian Dinosaurs.

ECONOMY

The International Center of Export of Trade organizes a discussion on opportunities for exporting Mongolian goods in the U.S, Canada, and Japan markets. Also, they introduced the Mongolian brand shopping center in Chicago.

The Mongolian Economic Forum 2019 to be held on September 25-26.

Top 20 index up 0.29 percent to 20,651.55. MSE A index increases 0.22 percent to 9,685.61 points. MSE B index rises 1.05 percent to 8,044.34 points. Market cap stands at MNT 2,58 trillion.



SOCIETY

The Silk Way long-distance automobile and motorcycle rally to take place in the Mongolia, Russian Federation, and the People's Republic of China between July 6 and 16.

First Deputy Head of the National Emergency Management Agency (NEMA), Brigadier General receives representatives led by Head of the Seoul Metropolitan Fire and Disaster Headquarters on July 3.

Naadam opening to be performed for foreign visitors



Batsaikhan.S / ZGM©

The standard ticket price is MNT 16,000-24,000

Aminaa.U
ZGM

Naadam Festival 2019 will be held at the National Amusement Park at 21.00 pm for foreign visitors. The official opening ceremony of the Naadam Festival takes place at the National Sports Stadium in Mongolian. Therefore, foreign tourists cannot fully understand the meaning of content. This year, the Ministry of Environment and

Tourism decided to re-organize the opening as Naadam Night show in English.

Also, there is a problem of lack of opening ceremony ticket. National Sports Stadium has only 12,300 seats and finding tickets is a big problem tourists face every year. A total of 15,000 tourists submitted a request to watch Mongolia's traditional festival opening ceremony. However, around 1500 tickets were allowed to the tourists. This year, the standard ticket price is MNT 16,000-24,000 the same as the last year.

"The Stadium has 13,500 seats, and tourists can receive 3500 of it. This is our capability. If we allow all the tourists who want to attend the opening of the Naadam

Festival to enter the Central Stadium, Mongolians cannot watch their traditional festivals. We are aiming to receive one million foreign tourists in 2020, making an effort to improve sanitation standards in tourism zones," the Minister of Environment and Tourism Tseerenbat Namsrai said to the press.

In Mongolia, the tourism season starts in May, and travelers tend to be attracted by Naadam Festival. There is statistical data on an average of 450,000 tourists visit Mongolia annually. However, according to the officials, the number of tourists visiting Mongolia only exceeds 90,000 per year.

During Naadam, National





Tourists came to Mongolia decreased by 4.8 percent last year

Sports Stadium become extremely crowded, due to the centralized trade and trade services. "730 organizations, which include food, souvenirs, handicrafts, and other trading will work in the stadium and Khui Doloon Khudag. Under General Manager of Ulaanbaatar's order related to Naadam, the

Metropolitan Professional Inspection Department, Police Department of Ulaanbaatar city, and the Mayor's office of all districts will jointly work in maintaining security," said the spokesman.

The number of tourists came to Mongolia last year decreased by 4.8 percent. The decline in tourists from China and Australia was the key factor to it. Although the total number of tourists has dropped, tourists from Ukraine and Hong Kong have risen. In particular, the tourists from Ukraine increased by 37.2 percent compared to last year. Traveling flow between the two countries has doubled since the adoption of the non-visa law to Russia. [ZGM]

COMMODITY MARKET



Bloomberg©

LEGISLATION

Mongolia bans exports of living livestock

The Mongolian government on Wednesday banned exporting live livestock animals and pushed forward plans to improve its meat processing capacity, according to the government's press office.

"Previous governments' decisions on exporting live livestock animals have been

overturned. Prime Minister Ukhnaa Khurelsukh has ordered relevant officials to pay special attention to increasing the capacity of existing meat processing plants and building new ones in order to raise meat exports," according to the government press.

Animal husbandry is the

backbone of Mongolia's economy as nearly 40 percent of the country's nomad population depends on animal husbandry for their livelihood. As one of the last nomadic countries in the world, Mongolia has more than 66.46 million livestock animals as of the end of 2018, according to the

National Statistics Office.

Mongolian Minister of Food, Agriculture and Light Industry Ulaan Chultem said in May that the country earned around USD 190 million from meat exports in 2018, with most of the revenue coming from its exports to China. [ZGM]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.07.05

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: УСУГ-ын ус зөөврийн автомашин /5ш/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2019-141

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос усны зөөврийн автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 3 жил /2016, 2017, 2018/ тус бүр тухайн барааны төсөвт өртөгийн 70 хувиас дээш байх.

Тендерийн хамт 14,000,000 /арван дөрвөн сая/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийг дуустал.

Тендерийг 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 09 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

Өдрийн хэмнэл

ЗУРХАЙ

Билгийн тооллын 3

Зуны адаг цагаагчин хонь сарын дөрвөн ногоон мэнгэтай харагчин туулай өдөр



Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх: 05.03-20.54
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Хий

Аргын тооллын долдугаар сарын 5, Сугар гараг. Билгийн тооллын 3. Үнэг одтой, харагчин туулай өдөр. Өдрийн наран 05.03 цагт мандан, 20.54 цагт жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, мал аж ахуйн үйл, удирдлагын суудал суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сэтэвтэй газар очих, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод урагш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр.

ЗГМ: СУДОКУ

	4	5		9	6				
6	8				5	4	9		
			1	2	3			4	
5		3			8				
		8	6				1		
			4	2					
9									5
8	6								3

4	7	1	9	6	3	8	5	2	
6	5	8	7	1	2	9	3	4	
9	2	3	4	5	8	6	7	1	
8	3	5	2	7	6	1	4	9	
1	6	9	8	4	5	3	2	7	
2	4	7	1	3	9	5	8	6	
7	1	6	5	8	4	2	9	3	
5	9	4	3	2	1	7	6	8	
3	8	2	6	9	7	4	1	5	



Playtime Festival 2019
Хаана: Gachuurt Village
Хэзээ: 2019.07.05-нд
Тасалбарын үнэ: ₮ 50-100 мянга



Stand Up Comedy
Хаана: Comedy Lab Club
Хэзээ: 2019.07.05-ны 21.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга



Legend шоу
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2019.07.12-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 39900

ОНЦЛОХ ҮЗВЭР

Хийморь сэргээсэн хүрэн морины түүх



Чулуун хүү болон түүний хайртай хүрэн морины түүхийг өгүүлэх "Хийморь" уран сайхны кино зургадугаар сарын 25-наас кино театруудын дэлгэцнээ гарч байна. Чулуун хүүд ээж нь хүрэн мориноосоо битгий холдоорой гэж захижээ. Гэвч хүү нэгэн өдөр хайртай морио алдчихав. Морийг нь дайнд дайчлахаар хүний нутаг руу авч оджээ. Гэвч хүрэн морь нутаг руугаа гүйн ирнэ. Энэ хооронд хүрэн морины замд сайн, муу янзын хүмүүс тааралдаж, олон адал явдал тохиолдох болно. Бүх насныханд зориулсан "Хийморь" уран сайхны киноны зохиолыг Г.Эрдэнэбилэг бичиж, өөрөө найруулжээ. Киноны гол дүрүүдэд Э.Ариунболд, П.Цэрэндагва, Д.Мэндбаяр, Г.Эрдэнэбилэг, Василий Мищенко, Нурлан Алимжанов нар тоглосон байна. [ЗГМ]



"Удшийн музейд" концерт
Хаана: Чойжин ламын сүм музей
Хэзээ: 2019.07.08-ны 20.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 60 мянга




"Монголын сайхан орон" морин хуурын чуулга
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.07.11-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 30-50 мянга



ТХШ, АЖ Л.Мөрдорж 100 жилийн ойн тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2019-09-20-нд
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



3. Мужааны багаж
4. Хэнтийн нурууны ноён оргил ... хайрхан
6. Тайгын бүслүүрийн дээр орших оройн бүслүүр
7. Тэмээг эдэлгээнд ашиглахын тулд хамарт нь хийх шөрөг
8. Манжийн үед бэлэг сэлт, арилжаа наймаанд хэрэглэгддэг байсан алт, мөнгөн эдлэл
9. Бичлэгийн нэг төрөл
11. 2,5 см-тай тэнцэх хэмжүүрийн нэгж
13. Ганц гэсэн үг

БОСООГООР:

1. Эхнэр, нөхрийн эцэг

ЭХЧҮҮД

2. Нэгэн төрлийн даам

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Говь, талд ургадаг бутлаг ургамал
4. Уртын хэмжээ
5. Дээр үеэс монголчуудын гал гаргадаг асан хэрэгсэл
10. Тэнгэрийн хүндэтгэлийн нэр
11. Мөнх хааны зарлигаар дүү Хүлэгүгийнх нь байгуулсан улсын нэр (... хаант улс)
12. Онон голд цутгадаг голуудын нэгэн
14. Уламжлалт эмчилгээний эм
15. Агаар тэнгэрт гарсан усан бөөгнөрөл

16. Дайснуудтай нь нийлэн Чингис хаантай байлдаж

байсан Ойрадуудыг нэрлэх нэр (... иргэд)

Өмнөх дугаарын хариу / 07.04

А	С	Р	А	Л	Т	Х	А	И	Р	Х	А	Н
Р	Е		А		А	С		У		Ө		
З	Ө	Н		М	О	Н	Е	Л		У	У	Ж
У	О		Б		Т	А		З		И		
	Р	С	А	Р	А	А	Н	А	Р			
		А	А		Й		Д	Г				
		А	У	Ш	У	Э						
		С		И		Э						
		С	А	Р	Б	С						

Эдийн засаг, бизнесийн мэдээлэл
24 цагаар таны сонорт..

ЭДИЙН ЗАСАГ

Амь үрэгдэгсдийн ар гэрт Boeing компани \$100 сая төлөхөөр шийджээ

737 Мах-ын сүйрлийн улмаас нисэх онгоц үйлдвэрлэгч шүүхийн олон заргад орооцолдоод байна. > 10

Samsung дэлгэцийн гажигтай нугалдаг утсаа засаж дуусгалаа

Samsung ухаалаг утасны зах зээлд дахин цохилт хүлээхгүйн тулд бүх чадлаа дайчилж байна. > 10

Хятад тэрбумтан саатуулагдсан нь үл хөдлөх хөрөнгийн гүрнийг доргиов


Ван Жэньхуаг "хувийн асуудал"-аар саатуулсан хэмээн Future Land мэдэгдэв. > 10

41 Үүгээр Сөүл маргааны эхлэлийг тавьсан гэж Токио буруутгаж буй. Энэ маргаан эцэстээ АНУ-ын худалдааны гол хоёр түншийн хоорондын зөрчил хяналтаас гарч мэдэх эрсдэл бий болгов.

Стэнфордын их сургуулийн олон улсын бодлогын профессор Даниел Шнайдер "Эдийн засгийн дайны эхний алхам хийгдлээ. Маш аюултай өрнөл" хэмээн сануулав. Хойд Солонгосын цөмийн аюул, Хятадын цэргийн хүчин чадал өсөж буй цаг үед АНУ хоёр холбоотных нь маргаан хурцдахад зохицуулах арга хэмжээ авч байв. Гэтэл Ерөнхийлөгч Трамп Япон, Өмнөд Солонгост цэргээ хугацаагүй байрлуулах гэрээнд эргэлзэж буйгаа илэрхийлсний дээр Цагаан ордон Азийн түншүүдийн маргааны талаар үг дуугарахгүй байна.

Доктор Шнайдерын хэлснээр Трамп саяхан Токио, Сөүлд айлчилсан боловч зөрчлийг намжаах үг хэлээгүй нь маргааныг дэвэргэх нэг шалтгаан болж магадгүй юм. Тэрбээр "Зүүн хойд Ази дахь хоёр холбоотны маргаан хурцдах нь манай үндэсний аюулгүй байдалд эрсдэл үүсгэнэ гэдгийг америкчууд үргэлж ойлгодог. Харин энэ засаг захиргаа хариуцлагаа орхигдууллаа" хэмээн шүүмжлэв. Төрийн департаментын нэрээ хэлэхийг хүсээгүй нэг албан тушаалтан тус бүс нутгийн сорилтын өмнө АНУ, Япон, Өмнөд Солонгос улсууд нэгдмэл байхын чухлыг онцлолоо.

АНУ зуучилсны үр дүнд 1965 онд Японоос Өмнөд Солонгост дайны төлбөр болгож 300 сая



Япон, Өмнөд Солонгосын маргаан улам хурцадлаа

ам.доллар (өнөөгийн ханшаар 2.4 тэрбум) олгох гэрээ байгуулсан. Тухайн үед бүх маргааныг үгнэгт шийдлээ гэж үзэж байв. Өмнөд Солонгосын авторитари Засгийн

газар уг мөнгийг аж үйлдвэрээ хөгжүүлэхэд зарцуулсан. Гэвч колонишлалын үед хүчинд автан ажилласан солонгосчууд хийгээд Японы цэргүүдэд

секс үйлчилгээ үзүүлж байсан эмэгтэйчүүдийн сэтгэл санаанд үлдсэн шарх сорвийг дээрх гэрээ арилгасангүй. Маргаан үүсэхэд хоёр Засгийн

газар гүнзгий холбоотой эдийн засгийн харилцаагаа хөндөхөөс зайлсхийж байв. Гэвч Өмнөд Солонгосын дээд шүүх 18 гомдол мэдүүлэгчийн хэргийг

хянан хэлэлцээд тус бүрт нь 88000-134000 ам.доллар олгуулах шийдвэр гаргасан нь уг зөвшилцлийг эвдсэн юм. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мун Жэ Ин 1965 оны гэрээ солонгосчууд Японы компаниудын эсрэг зарга үүсгэхийг хориглоогүй учир дээд шүүхийн шийдвэрийг хүндэтгэх ёстой гэж мэдэгдсэн. Солонгосчууд олон зуун мянгаараа албан журмын хөдөлмөр эрхэлж байсан тул заргын тоо өсөж магадгүй. Японы Гадаад хэргийн яамны мэдээлснээр тус улсын 70 компанид хамаатай арав гаруй хэргийг Өмнөд Солонгосын шүүхээр хэлэлцэхээр хүлээгдэж байгаа аж. Японы тал 1965 оны гэрээнд суурилан арбитрын асуудал сөхөн тавьсан ба Өмнөд Солонгостой хамтарсан сан байгуулахыг санал болгожээ. Гэвч Ерөнхийлөгч Мун Жэ Ин 2015 онд байгуулсан санг татан буулгаж, хүчээр сексийн үйлчилгээ үзүүлсэн эмэгтэйчүүдээс ноён Абэ биеэр уучлал хүссэнийг хэрэгсэхгүй болгосон явдалд Токио сэтгэл дундуур байна.

Японоос Өмнөд Солонгост нийлүүлж байсан чипийн материалуудыг хязгаарласан явдал Samsung, Hynix зэрэг компаниудын хувьцааны үнэ буурахад хүргэв. Сөүл уг асуудлыг Дэлхийн худалдааны байгууллагад тавихаар төлөвлөж буй. 2011-2013 Токиод Элчин сайдаар ажиллаж асан Как Су Шин "Зөрчил хурцалсаар маш аюултай, гарцгүй шатандаа орж болзошгүй. Сөүл, Токиогийн хооронд ангал үүсвэл хэн хожихыг тэд нухацтайгаар тунгаах ёстой" хэмээн анхаарууллаа.

Д.Трамп Азийн гангийн импортод нэмэлт тариф тогтоов

Филип Хейжманс

АНУ-ын засаг захиргаа Азиас ирж буй гангийн импортод нэмэлт тариф тогтоосноо худалдааны шударга бус практикийг зогсоох арга хэмжээ хэмээн мэдэгдэв. Худалдааны яамнаас лхагва гаргагт гаргасан мэдэгдэл "Хятадаас ирж буй зарим ган бүтээгдэхүүн өртгөөсөө доогуур үнээр зарагдаж, шударга бусаар татаас авч байгаа учир нэмэлт тариф ногдуулсан" хэмээн онцолжээ. Өмнөх өдөр нь тус яам Вьетнам улс демпинг ба

татаасын эсрэг журмыг зөрчиж байгаа учир ган бүтээгдэхүүнд нь 400 хувийн тариф ногдуулна гэж мэдэгдсэн.

Түүнчлэн Өмнөд Солонгос, Тайвань улс үйлдвэрлэсэн зарим ган хийцийг Вьетнамд авчирч, үл ялиг боловсруулалт хийгээд АНУ руу экспортолж байна хэмээн буруутгажээ. Худалдааны яам энгийн журмын дагуу демпингийн эсрэг судалгаа явуулсны үгнэгт дээр нэмэлт тариф тогтоож байгаа нь Хятадын импортод ногдуулсан

тарифаас зарчмын ялгаатай юм. Гэсэн ч энэ арга хэмжээ худалдааны сөргөлдөөнд пучил нэмэх нь дамжиггүй.

Осака дахь Их 20-ийн дээд чуулганы үеэр Трамп, Ши нар уулзаж, худалдааны гэрээг сэргээн эвлэрэл зарлах тохиролцоонд хүрсэн авч гол санал зөрөлдөөн шийдэгдээгүй хэвээр байна. Хятадын тал эдийн засгийн загвараа өөрчилж, Америкийн компаниудад шударгаар өрсөлдөх боломж олгох ёстой гэж

Вашингтон шаардсан.

Үүний сацуу АНУ-ын засаг захиргаа Вьетнамын эсрэг шүүмжлэлээ хурцлав. Хятадтай үргэлжилж буй худалдааны дайнаас ихээхэн ашиг хүртдэг Вьетнам улс Ази дахь АНУ-ын томоохон худалдааны түнш болсон. Гэвч ноён Трамп Вьетнамыг "хамгийн ноцтой журам зөрчигч" гэж нэрлээд тэдний эсрэг тариф тогтоох ёстой гэсэн асуудлыг хөндсөн юм. Вьетнамын Гадаад хэргийн яам энэ

асуудлаар тайлбар өгөх хүсэлтэд хариу өгсөнгүй. Хятад улс ган бүтээгдэхүүнээ өөрийн өртгөөс нь доогуур үнээр экспортолж, гуравдагч орнуудаар дамжуулан АНУ руу гаргаж байгааг Трампын засаг захиргаа шүүмжилсэн. ING банкны эдийн засагч Роб Карнелл "Компаниуд өндөр татвараас зугтахын тулд Вьетнам мэтийн улсуудаар дамжуулахыг оролдох нь гайхаад байх зүйл биш. Нэг их ухаан зарах ч хэрэггүй. Үнийг нэмчихээр хүмүүс түүнийг тойрч

гарахыг оролддог. Энэ бол хүний мөн чанар" гэв.

Вьетнамын тал АНУ-тай хийж буй худалдааны тэнцлийн илүүдлээ багасгах арга хэмжээ авч, тарифаас зайлсхийхийн тулд тус улсаар экспортоо дамжуулж буй Хятадын үйлдвэрлэгчдийг хориглосон гэж мэдэгдэв. Ханой дахь АНУ-ын ЭСЯ тус улсын эрх баригчидтай уг асуудлаар ярилцсанаа мэдээлээд "Вьетнам манай тавьсан шаардлагыг ойрын үед шийдэх алхмууд хийнэ" гэжээ.



Shiseido сарын \$92-оор төгс нүүр царай санал болгов

Мей Футонака

Гоо сайхны Shiseido компани төгс нүүр царайг хадгалах үйлчилгээг сарын 10000 иенээр санал болгожээ. Хэрэглэгчид Японы гоо сайхны бараа үйлдвэрлэгчийн арьс арчилгааны төлбөрт үйлчилгээг Optune төхөөрөмжөөр худалдан авах юм. Гар утасны апп хэрэглэгчийн арьсанд анализ хийж, таван төрлийн арчилгааны бодис ашиглан тухайн хүнд тохирох найрлагыг зааж өгнө гэж компанийн төлөөлөгч яриллаа. Optune 80 мянган хувилбараас өдөрт хоёр удаа хэрэглэгчид тохирсон найрлагын тос гаргаж өгөх зориулалттай. Shiseido 440 тэрбум ам.долларын багтаамжтай дэлхийн гоо сайхны бүтээгдэхүүний зах зээлд сүүл мушгиж, технологи нэвтрүүлж байгаа нь энэ юм. Өнгөрсөн онд Францын L'Oréal нүүрний энгэсэг тавихад яаж харагдахыг үзүүлдэг ModiFace үйлчилгээг худалдан аваад байв.



Бээжин сайн санааны үүднээс АНУ-ын фермийн бүтээгдэхүүнийг худалдан авна

Хятадын эрх баригчид худалдааны хэлэлцээ үргэлжлэх завсар сайн санааны бэлгэдэл болгож, АНУ-аас фермийн бүтээгдэхүүн худалдан авах асуудлыг судалж байна. Эх сурвалжийн хэлснээр хэмжээ нь урьдын худалдан авалтад хүрэхгүй бөгөөд эхний алхам болох юм. Үүнд шар буурцаг, эрдэнэшиш, гахайн мах орох юм байна. Хэлэлцээний явцаас шалтгаалан импортын хэмжээг тогтоох аж. Ерөнхийлөгч Трамп, Ши нар худалдааны эвлэрэл зарласан боловч Хятадын тал хэт их зүйл амлахаас болгоомжилж байгаа бололтой. Өнгөрсөн оны сүүлээр түр эвлэрэл зарлах үед Хятадын тал АНУ-аас 20 сая тонн гахайн мах, шар буурцаг, эрдэнэшиш худалдан авсан юм. Энэ мэдээний дараа Чикагогийн таваарын бирж дээр гахайн махны фючерсын үнэ дээшиллээ.

УУЛ УУРХАЙ, БАРИЛГА, ЗАМЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТҮРЭЭСИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

Манай түрээсийн үйлчилгээний онцлог:

1. Шинэ машиныг шууд ашиглах
2. Түрээслэхээс өмнө турших боломжтой
3. Тооцоологдсон зардал бусад шийдлүүдтэй
4. Хугацаа, тоо хэмжээг өртгөтгөн түрээслэх боломжтой

ЮУ ХЭРЭГТЭЙ, ТҮҮНИЙГЭЭ ТҮРЭЭСЛЭЭРЭЙ :)

НАЙДВАРТАЙГ ТҮРЭЭСЛЭ!

WAGNER ASIA

CAT Rental

7575-RENT (7368)

УЛААНБААТАР САЛБАР: 9900-7728, 9909-8857, ХАНБОГД САЛБАР: 9907-7493

Эдийн засаг

Рик Клоф

Нийт 346 хүний амь авч, шүүхийн олон зарга дэгдээсэн болсон Max 737 онгоцны хоёр ослоор эндсэн хүмүүсийн ар гэрийнхэн, хохирогсод 100 сая ам.доллар нөхөн төлөх саналыг Boeing Co тавилаа.

Уг мөнгийг “хохирогсдын ар гэрийнхний боловсрол, амьдралын зардал, нийгмийн зориулалттай хөтөлбөр, эдийн засгийг хөгжүүлэх үйлс”-т зориулна хэмээн мэдэгдсэн ба нөхөн төлбөрийн мөнгийг хэдэн жилд цувиулж олгох юм байна. “Эхний хүртээмж” хэмээн тодорхойлсон уг амлалт 103 жилийн түүхэнд нь хамгийн хүнд цаг тохиосон Boeing-д том бооцоо юм. Хоёр удаагийн аймшигт сүйрлийн улмаас Max 737 цувралын агаарын хөлгүүдийг газардуулахаас аргагүй болсон нь түгшсэн зорчигч, хөрөнгө оруулагч,

болохоос өмнө нисэх онгоцны хийцийн “цоорхой”-г Boeing мэдэж байсан нь батлагдвал аваас нөхөн төлбөрийн хэмжээ улам ихэснэ хэмээн Bloomberg Intelligence болон хууль зүйн экспертүүд үзэж байна.

Хоёр дахь онгоцны сүйрлээр амь үрэгдсэн 23 хүний өмнөөс заргалдаж буй Чикагогийн өмгөөлөгч Роберт Клиффорд Boeing-ын саналыг “тун ч ердийн бус” хэмээн тодорхойлов. Хохирогсод туслах иймэрхүү амлалт ихэвчлэн элдэв болзол, хязгаарлалттай байдгийг тэрбээр онцлон анхааруулсан юм.

Нью-Йорк хотноо Тусгаар тогтнолын баяртай холбогдуулан эрт хаасан лхагва гарагийн арилжаагаар Boeing-ын хувьцааны үнэ өөрчлөлттэй гарч, 354.47 ам.доллар байлаа. Таван сарын дотор тохиолдсон хоёр дахь осол буюу



Этиопын Бишофүгийн ойролцоо осолдсон Ethiopia Airlines-ын онгоцны үлдэгдэл.

Амь үрэгдэгсдийн ар гэрт Boeing компани \$100 сая төлөхөөр шийджээ

үйлчлүүлэгч, зохицуулах байгууллагуудын зүгээс Чикагод төвтэй компанийг нарийвчлан шалгаж, хянуур хандах шалтгаан болов.

Амь үрэгдсэн хүмүүсийн өмнөөс үүсгэсэн олон заргын нийт зардал Boeing-д нэг тэрбум ам.долларын өртөгтэй тусахаар байна. Эмгэнэлт осол

гуравдугаар сарын 10-нд Ethiopian Airlines-ын онгоц сүйрснээс хойш Boeing-ын хувьцааны үнэ нийт 16 хувиар унаад байна.

Тусламжийн санг улс орнуудын засгийн газар, ашгийн бус байгууллагуудын оролцоотой байгуулахаар Boeing төвлөжээ. Ослоор эндсэн нэг

хүнд оногдох төлбөрийн дундаж 289,000 ам.доллар ч бодитой төлөх үед энэ хэмжээ багасаж болзошгүй аж. Төлбөр зарцуулахтай холбоотой ямар ч хязгаарлалт, болзол тавихгүй хэмээн Boeing-ын төлөөлөгч Чарльз Бикерс мэдэгдэв.

Индонезийн агаарын шугамын ослоор амь үрэгдсэн

хүмүүсийн өмнөөс үүсгэсэн 46, мөн Ethiopian Airlines-ын ослын хохирогсдын бараг адил тоотой заргыг шүүхэд өдгөө хэлэлцэж байна.

Ослын дараа Boeing-ын үйл ажиллагаанд эрс шүүмжлэлтэй хандаж буй амь үрэгдсэн хүмүүсийн ар гэрийнхний зарим нь АНУ-ын Конгрессын

сонголд оролцож, АНУ-ын Холбооны Нислэгийн Удирдах Газар, Үндэсний Тээврийн Аюулгүй Байдлын Зөвлөлийн удирдлагуудтай уулзсан юм.

Эмгэнэлт ослын дараа цалгар назгай ажилласан хэмээн шүүмжлүүлсэн Boeing-ын гүйцэтгэх захирал Деннис Муйленбург лхагва гарагт

гаргасан мэдэгдэлдээ “хоёр ослоор амь үрэгдсэн хүмүүсийн төлөө” хэмээн хохирогсдын ар гэрийнхнээс дахин уучлал гуйв. Boeing компани Max онгоцонд өнгөрсөн долоо хоногт илэрсэн аюулгүй байдлын шинэ дутагдлыг залруулах программ хангамж хөгжүүлж буйг тэрбээр мөн тайлбарласан юм.



Сам Ким

Samsung Electronics Co дэлгэцний гэмтлээс болж худалдаанд гарах товгыг нь хойшлуулсан Galaxy Fold загварынхаа хийцийг бүтэн хоёр сар шинэчилж дуусгасныг эх сурвалж мэдээллээ. Хийц сайжруулалт дуусмагц Өмнөд Солонгосын аварга үйлдвэрлэгч ач холбогдолтой ухаалаг утсаа зах зээлд гаргах боломтой боллоо.

Дэлхийн ухаалаг утасны тэргүүлэх үйлдвэрлэгч Galaxy Fold-ын худалдааны хувилбарыг үйлдвэрлэх сүүлчийн шатанд орсон ч борлуулах тов нь харахан тодорхойгүйг компанийн дотоод

мэдээллийг задруулж буй нэрээ дурдахыг зөвшөөрөөгүй эх сурвалж тайлбарлав. Туршилтын хувилбарын дэлгэцнээ наалттай хамгаалалтын хальсыг хуулмагц дэлгэц доголдож байгааг Bloomberg News зэрэг мэдээллийн хэд хэдэн хэрэгсэл мэдэгдсэний дараа Samsung ухаалаг төхөөрөмжөө зах зээлд гаргахаа хойшлуулсан юм.

Өмнөд Солонгосын тэргүүлэх компани ээлжит бүтээгдэхүүнээ бүтэлгүйтэхээс сэргийлэн эрчимтэй ажиллав. Энэ удаа дэлгэцийг бүрсэн хамгаалалтын хальсыг гадна ирмэгийн дотор тал руу оруулсан тул гараар

хуулж авах аргагүй болсныг сайжруулсан хувилбартай нь танилцсан хүмүүс өгүүлж байна. Мөн нугасны хийцийг сайжруулж дэлгэцтэй нэг түвшинд үл ялиг

өргөж өгсөн тул ухаалаг утсыг дэлгэхэд өмнөхөөсөө эвтэйхэн болжээ.

Шинэ шийдэлд илүү хатууруулж өгсөн хамгаалалтын хальс урьдынх шиг хуулж авдаг тусдаа эд бус, утасныхаа цогц бүрдэл болж чадлаа. Энгийн нүдэнд бараг анзаарагдахгүй үл ялиг товойлгосон нь хэрэглээний

явцад дэлгэцийн гол хэсэгт нугалаас үүсэхээс сэргийлсэн хэрэг хэмээн зарим нь тайлбарлаж байна.

Анх дөрөвдүгээр сарын 26-нд зах зээлд нийлүүлэхээр төлөвлөсөн 1,980 ам.долларын үнэтэй Galaxy Fold нь Samsung-ын чухал бүтээгдэхүүн. Уг загвар нь Apple Inc-тэй өрсөлдөх, Huawei Technologies Co зэрэг хятад өрсөлдөгчдөөсөө тасрахад нь Samsung-д тус болох учиртай, дэлхийд хамгийн анхны масс үйлдвэрлэлийн нугалдаг дэлгэцтэй ухаалаг утас юм. Bloomberg-д ирүүлсэн анхны хувилбар хамгаалалтын хальсыг хуулснаас хойш удалгүй ажиллахаа больж, нугастай харалдаа нугалдаг хэсгээрээ бяцхан цуурчээ.

Galaxy Fold-ыг угсрах үндсэн үйлдвэр байрлаж буй Вьетнам руу үндсэн бүрдлүүдийг удахгүй тээвэрлэж эхлэх төлөвлөгөөтэй Samsung компани бүтээгдэхүүнээ


зах зээлд нийлүүлэх товоо харахан тогтоогүй байгааг эх сурвалж өгүүлсэн юм. Юутай ч Нью-Йорк хотноо наймдугаар сарын 7-нд танилцуулах шинэ шилдэг загвар Note 10-тай зэрэгцүүлэхгүй хэмээн зарим нь таамаглаж байна. Таамагтай холбогдуулан тайлбар өгөхөөс Samsung-ийн төлөөлөгчийн газар татгалзлаа.

Хойшлогдсон Fold нь Samsung компани инновацаар зах зээлд тэргүүлж, өсөлт нь саарсан ухаалаг утасны зах зээлд шинэ түлхэц өгөхөд тус болно. Өмнөд Солонгосын Сувонд төвтэй тус компани урьд нь 2016 онд зай хураагуурын гологдлоос болж шатах эрсдэлтэй Note 7 загвараа зах зээлээс эргүүлэн татаж байв. Мөн өрсөлдөгч Huawei компани нугалдаг дэлгэцтэй загвараа зах зээлд нийлүүлэх товгыг хойшлуулсан нь Samsung-ыг яарх шалтгаангүй болгосон хэмээн зарим эх сурвалж тайлбарлав.

Хятад тэрбумтан саатуулагдсан нь үл хөдлөх хөрөнгийн гүрнийг доргиов

БНХАУ-ын тэрбумтан Ван Жэньхуаг Шанхайн цагдаагийн газар саатуулсан нь Хонконгийн биржид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн компанийнх нь хувьцаа, бондын үнийг унагав. Future Land Development Holdings Ltd-г үндэслэгч, 57 настай Ванг Шанхайн Нийгмийг Аюулаас Хамгаалах Хорооны Путоу салбар “хувийн асуудал”-тай холбоо бүхий эрүүгийн хэрэгт сэжиглэн саатуулсан аж. Тус компанийн мэдээллээс үзвэл Future Land-ын тэргүүний албан тушаалыг Ван Жэньхуа хүүдээ залгамжлуулах гэж байв.

Future Land-ын хөрөнгө оруулагчтай харилцах болон хэвлэл мэдээллийн алба нь утасны дуудлагад хариу өгөхгүй байна. Шанхайн Нийгмийг Аюулаас Хамгаалах Хорооны албаны хүн ч гэсэн тайлбар өгөхгүй хэмээн мэдэгдлээ. Путоугийн цагдаагийн



газар хоёр хүнийг насанд хүрээгүй хүүхдэд халдсан хэргээр саатуулж байгаагаа лхагва гарагт сошиал медиад постолсон юм. Сэжигтний нэг нь Шанхайн умардын Жянеу мужийн 57 настай Ван овогт хэмээн товч бичжээ. Цагдаагийн газар сэжигтний талаар илүү тодорхой зүйл бичсэнгүй.

Ванг саатуулсан нь лхагва гарагт Future Land-ын хувьцаа

эрс унах шалтгаан болсон юм. Мөн дөрөвдүгээр сард арилжсан, 2023 онд төлөх ёстой бондынх нь үнэ ч буурав. Future Land нь MSCI Inc-ийн глобал индекст багтдаг, 5.2 тэрбум ам.долларын зах зээлийн үнэлгээтэй компани. Пүрэв гарагт тус компанийн хувьцааны үнэ дахиад 15 хувиар унасан юм.

Хөх мөрний бэлчирт бизнес нь төвлөрдөг Future Land-ын

70 хувийг Ван өөрөө эзэмшдэг. Шанхайд төвтэй, Хятад даяар 100 гаруй шопинг молл бүхий тус компани 2018 онд 54.8 тэрбум юанийн (найман тэрбум ам.доллар) орлоготой ажиллажээ. Ван нь мөн саяхан нэрээ Xinchengyue Holdings Ltd болгон өөрчилсөн үл хөдлөх хөрөнгийн менежментийн S-Enjoy Service Group Co-гийн хувьцааний ихэнхийг эзэмшдэг. Мягмар гарагийн байдлаар Ван Жэньхуагийн хөрөнгө 6.6 тэрбум ам.доллар болж байгааг Bloomberg-ийн тэрбумтны жагсаалтаас харж болно.

Энэ хөрөнгө лхагва гарагт Future Land, S-Enjoy-н хувьцааны үнэ унамагц 1.6 тэрбум ам.доллараар багассан юм.

“Захирлыг саатуулсан нь компанид ноцтой асуудал” гэж Сингапурт төвтэй Lucrator Analytics Pte-гийн Азийн салбарын тэргүүн Чарльз МакГрегор анхааруулав. Ван

Ван Жэньхуаг “хувийн асуудал”-аар саатуулсан хэмээн Future Land мэдэгдээд байна



үүргээ гүйцэтгэж чадахгүй бол Future Land-ыг өрсөлдөгчид

нь өөртөө нэгтгэх аюулыг МакГрегор тайлбарлаж байна.

Төв банкны мэдээлэл

ХУДАЛДААНЫ ДАЙН

Хэдийгээр “Их 20”-ын уулзалтын үеэр АНУ болон БНХАУ нэг ширээний ард сууж, хэлэлцээрийг дахин эхлүүлснээр худалдааны маргаанд найдварын гэрэл тусаад байгаа ч гэлээ бүрэн шийдэгдээгүй хэвээр байна. АНУ-ын эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдлын индекс жилийн өмнө 10 хувиар өссөнөөс хойш хөгжиж буй орнуудын бүтээгдэхүүний өсөлт 0.6 хувиар, хөрөнгө оруулалтын өсөлт мөн 0.6 хувиар буурлаа. Өөрөөр хэлбэл Монгол Улс шиг хөгжиж буй орнууд худалдааны маргаанаас хамгийн их хохирол үзэхээр байна. Эдгээр улсуудын экспортын болон худалдааны зардал өссөөр байна. Энэ нь зарим цөөн улсад худалдааны шинэ гарцыг богино хугацаанд бий болгож, ашиг тусаа өгч болох ч, дэлхий нийтийн эдийн засгийн өсөлтийг бууруулж эхэллээ.

Түүнчлэн АНУ-ын авто болон сэлбэгийн импортын тариф өсч байгаа нь дэлхий даяарх үнийн сүлжээ (Value chain)-ний тогтсон системийг эвдэж болзошгүй нөхцөлд тулж ирлээ. Улмаар худалдааны маргаан дэлхийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн түвшинг бууруулж байна. Дэлхийн худалдааны түвшин 2017 оны сүүлээр хамгийн дээд хэмжээнд хүрч, түүнээс хойш огцом буурлаа. Худалдааны маргааны улмаас Хятад болон голлох хөгжингүй орнуудын экспортын хэмжээ, мөн орлого буурч байна.

ХУВИЙН СЕКТОРЫН ӨРИЙН ДАРАМТ

АНУ мөчлөг дагасан буюу эдийн засаг сэргэж байх үед төсвийн зөөлөн бодлого баримталж байгаа нь тус улсын хэт их засгийн газрын өрийг үргэлжлүүлэн нэмэгдүүлж байна. Үүнтэй зэрэгцэж АНУ-ын хувийн секторын эмзэг байдал мөн хүндэрчээ. Хувийн секторын ДНБ-тэй харьцуулсан өрийн хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Санхүүгийн хямралаас хойш АНУ-ын хувийн хэвшлийн өр барагдуулах чадвар сайжирсан боловч эдийн засаг удааширч, санхүүгийн нөхцөл байдал чангарахад өр барагдуулах чадвар буцаад сулрах эрсдэлтэй юм.

Хятад улсын хэмжээнд худалдааны маргааны нөлөөгөөр хувийн секторын ашигт ажиллагаа буурч, их хэмжээний өрийн дарамтад орлоо. Санхүүгийн бус секторын өрийн хэмжээ сүүлийн жилүүдийн хамгийн дээд түвшинд хүрсэн бөгөөд энэ нь нийт эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Хятадын засгийн газар өрийн дарамтын эсрэг төсөв болон мөнгөний бодлогын арга хэмжээ авч байна. Энэ нь ч эргээд хувийн болон төрийн секторын өрийг нэмэгдүүлэх хөшүүрэг болж хувирсан нь “бодлого урт хугацаанд үр ашгаа өгөхгүй нь” гэдэг дүгнэлтэд хүргэлээ.

Евро бүсийн хувьд ч засгийн газрын өр толгой өвчин болсоор байна. Тухайлбал, Европын гурав дахь том эдийн засаг Италийн засгийн газрын нийт өрийн хэмжээ ДНБ-ний 130 хувьтай дүйцэж нэмэгдлээ. Нийт Евро бүсийн хэмжээнд хувийн секторын өрийн дарамт бага боловч Францын хувийн секторын өр сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, ДНБ-ний 250 хувийн босгыг даваад байна.

САНХҮҮГИЙН СТРЕСС

Өндөр хөгжилтэй орнуудад айл өрхийн болон засгийн



Олон улсын эрсдэл Монгол оронд №1

Гадаад хүчин зүйлээс хамаарсан импортын үнийн нөлөөгөөр инфляци өсөж, эрэлт болон үйлдвэрлэл буурна. Монгол Улсын түүхий эдийн экспортын хэмжээ мөн буурснаар төлбөрийн тэнцлийн алдагдал, гадаад өр нэмэгдэнэ

Сүүлийн үед дэлхийн улсуудын хооронд үүсэж буй геополитикийн ойлгомжгүй байдал нь өндөр хөгжилтэй орнууд болон хөгжиж буй эдийн засгуудын итгэлийг сулруулж, хөрөнгө оруулалтын төслүүдийг

хойшлуулсаар байна. Үүний нэн тэргүүнд АНУ, Хятадын хоорондох худалдааны дайн бичигдэх бөгөөд цаашид Брексит, Иран улсын хориг, санхүүгийн секторын стресс багтана. Олон улсын улс төрийн тогтворгүй нөхцөл нь тодорхойгүй байдлыг

улам гүнзгийрүүлж худалдаа, хөрөнгө оруулалтын онцгой ач холбогдолтой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа тул 2019 онд гарсан өөрчлөлтүүд болон тэдгээрийн талаар энд товч тайлбарлаж байна.

Монгол Улс шиг хөгжиж буй орнууд худалдааны маргаанаас хамгийн их хохирол үзэхээр байна.

газрын өрийн хэмжээ өсөж, өрийн дарамт нэмэгдэв. Хятад улсаас санхүүгийн болон санхүүгийн бус салбараа дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловч эмзэг байдал оршоор байна. Банкны салбарт том дүнтэй зээлдэгчдийн тоо нэмэгдэж байгаа бол нөгөө талд нь чанаргүй зээлийн түвшин өссөөр байна. Үүний нөлөөгөөр ӨМӨЗО-ны анхны арилжааны банк Баошанг банк нь төлбөрийн чадваргүй болж дампуурлаа зарласнаар Хятадын мөнгөний зах зээлийн зардлыг өсгөж, зээл татрах нөлөөг бий болголоо.

Хөгжиж буй орнуудын хувьд хүүгийн түвшин бага байгааг ашиглан өрийг дахин санхүүжүүлэх замаар өрийн эргэн төлөгдөх хугацааг уртасгаж, нийт өрийн хэмжээг нэмэгдүүлсээр байна. Хөгжиж буй орнууд дахь өрийн дарамт нэмэгдэх, зээлжих зэрэглэл буурах зэргээс шалтгаалж ханш

сулрах дарамт үүслээ.

АНУ болон өндөр хөгжилтэй орнуудын төв банкууд ойрын хугацаанд бодлогын хүүгээ өөрчлөхгүй, зарим тохиолдолд бууруулах төлөвтэй байгааг мэдэгдэв. Гэхдээ бодлогын хүүгээ нэмэгдүүлэх хүлээлт зах зээлд оролцогчдын дунд оршоор байгаа нь хөгжиж буй орнуудад чиглэгдэх санхүүжилтэд саад болох, ам.доллар чангарах хандлагыг хадгалсаар байна.

● Худалдааны маргааны улмаас Хятад болон голлох хөгжингүй орнуудын экспортын хэмжээ, мөн орлого буурч байна.

● Евро бүсийн хэмжээнд хувийн секторын өрийн дарамт бага боловч Францын хувийн секторын өр сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, ДНБ-ний 250 хувийн босгыг даваад байна.

● Хөгжиж буй орнуудын хувьд хүүгийн түвшин бага байгааг ашиглан өрийг дахин санхүүжүүлэх замаар эргэн төлөгдөх хугацааг уртасгаж, нийт хэмжээг нэмэгдүүлсээр байна.

ИРАН УЛСАД ТАВИГДСАН ХОРИГ
АНУ 2019 оны дөрөвдүгээр сард Иран улсын газрын тосны худалдан авалтыг бууруулах шийдвэр гаргаснаар 2019 оны нэгдүгээр улиралд газрын тосны үнийг 27 хувиар өсгөв. Энэхүү шийдвэрийн улмаас ОХУ, Саудын Араб, Катар, Арабын Нэгдсэн Эмират Улс зэрэг нь газрын тос экспортоос олох ашгийг нэмэгдүүлсэн бол

ӨМӨЗО-ны анхны арилжааны банк Баошанг банк нь төлбөрийн чадваргүй болж дампуурлаа зарласнаар Хятадын мөнгөний зах зээлийн зардлыг өсгөж, зээл татрах нөлөөг бий болголоо.

газрын тос импортолдог, нефтийн бүтээгдэхүүний үнэ инфляцид нь ихээр нөлөөлдөг орнуудын хувьд асуудал болоод байна. АНУ, Иран улсуудын хооронд хурцадмал байдал бий болсноор Азийн дөрвөн том нефть импортолдогч Иранаас худалдаж авах нефтийн хэмжээг бууруулжээ. Тухайлбал БНХАУ, БНЭУ нь АНУ-ын шийдвэрийн дараа Иранаас авах нефтийн импортоо үлэмж хэмжээгээр бууруулжээ. Харин Япон, БНСУ Иранаас нефть импортолохоо зогсоогоод байна. Ингэснээр дөрвөн улсын нийт импортын хэмжээ тувдугаар сард жилийн дотор 1,798,090 баррелиас 386,021 баррель болж буурчээ. 2018 оны сүүлээр ОПЕК-аас нийлүүлэх газрын тосны хэмжээг дор хаяж 1.2 сая баррель буюу дэлхийн нийт эрэлтийн 1.2 хувьтай тэнцэх хэмжээний нийлүүлэлтийг танах шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр нь 2019 оны турш үргэлжлэх хандлагатай байгаа нь АНУ-ын Иран улсын эсрэг хориг арга хэмжээтэй давхцаж, нефтийн бүтээгдэхүүний үнийг өсгөн, дэлхийн эдийн засгийн өсөлтөд саад учруулж байна. Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд 2019 оны турш экспортын өсөлт удааширч байгаа ба түүхэн дундаждаа хүрэхгүй гэсэн хүлээлттэй байна.

БРЕКСИТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Их Британи улс Европын холбооноос гарах асуудал буюу Брексит хэрхэн шийдэгдэх нь тодорхойгүй хэвээр байна. 2019 оны тавдугаар сарын сүүлээр явагдсан Их Британийн сонгуулийн үр дүнгээс харахад 2016 оны бүх нийтийн санал хураалтын дүнтэй адил Брекситийн асуудал дээр хуваагдмал хэвээр байгаа аж. Брекситийн хэлэлцээрийг зорьсон хугацаанд шийдвэрлэлгүй удаа дараа хойшлуулсан шалтгаанаар ерөнхий сайд Тереза Мэй ажлаа өгөв. Энэхүү мэдээ нь Их Британи Европын холбооноос тодорхой хэлэлцээргүйгээр гарах (no deal exit) магадлалыг нэмэгдүүллээ. Хэрэв 10 дугаар сар гэхэд хэлэлцээрт хүрч чадахгүй бол Их Британи улсад өөр Иран улсын холбооны хооронд худалдааны үл ойлголцол үүсэх аюултай. Түүнчлэн санхүүгийн болон геополитикийн хүрээнд тогтворгүй нөхцөл үүсэх ноцтой байдалд хүрнэ. Брексит тогтсон хэлэлцээргүйгээр эцэсэлбэл Их Британи улсад бараа, үйлчилгээ экспортлодог орнууд худалдааны гэрээгүй болно. Монгол Улсын хувьд ноос, ноолуурын түншээ алдах магадлал бодитой.

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Дээр дурдсан нөхцөл байдлууд нь Монгол Улсын компаниудын үйл ажиллагааны зардлыг өсгөж болзошгүй. Улмаар, БНХАУ-ын бараа, бүтээгдэхүүний үнэ татварын нэмэгдлийн нөлөөгөөр өсөж, манай үйлдвэрлэлийн түвшин буурах эрсдэлтэй. Импортын үнийн нөлөөгөөр инфляци өссөнөөр эрэлт болон үйлдвэрлэл буурна. Нөгөө талдаа Монгол Улсын түүхий эдийн экспортын хэмжээ буурснаар төлбөрийн тэнцлийн алдагдал, гадаад өр нэмэгдэнэ. Эдийн засгийн энэ тушаа хөдөлмөрийн зах зээлээр дамжин, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэйг бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид анхаарах цаг хэдийн болжээ.

БАНК САНХҮҮ

Хөгжлийн банк ₮20 тэрбумаас дээш дүнтэй экспортын төсөлд зээл олгоно

Н.Ану

Монгол Улсын Хөгжлийн Банк (МУХБ)-наас удирдлагаа сольсон нэг сарын хугацаанд хийсэн ажил болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа талаар мэдээллээ. Үүний хүрээнд тус банкны санхүүгийн өнөөгийн үзүүлэлт, чанаргүй зээлүүдээ хэрхэн шийдвэрлэх болон зээл хүсэгчдэд тавигдах шаардлагыг

танилцуулав. МУХБ-ны 2019 оны I улирлын байдлаар нийт актив дөрвөн их наяд 244 тэрбум төгрөг байна.


Нийт зээлийн үлдэгдэл хоёр их наяд 577 тэрбум төгрөг, эрсдэлийн сан 366 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн хэмжээ 292 тэрбум төгрөгтэй тэнцжээ. Чанаргүй зээлдэгчдийг Засгийн газрын болон Монгол Улсын



Үндэсний аудитын газрын шалгалтаар олон нийтэд зарлаж, шийдвэрлэхийг МУХБ-ны удирдлагуудад даалгасны дагуу Хөгжлийн банк дотоод үйл ажиллагааныхаа бодлогыг шинэчлэн, зээлийн журамдаа өөрчлөлт оруулах талаар тус банкны шинэ удирдлага, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Амартүвшин хэвлэлийн хур-

лын үеэр дурдлаа. Мөн тэрбээр зээл хүсэгчдэд тавигдах хуулийн болон бодлогын шаардлагадаа 20 тэрбум төгрөг эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютын дүнгээс дээш хэмжээтэй санахүүжилт хүссэн, дунд буюу өөрчлөлт оруулах талаар тус банкны шинэ удирдлага, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Амартүвшин хэвлэлийн хур-

Эдийн засаг



ДЭЛХИЙН ДУЛААРЛАЛ ЖУУЛЧДЫГ МОНГОЛ РУУ ЧИГЛҮҮЛНЭ

Бараан мэдээ, хор хохиролтой зэрэгцээд цаг уурын өөрчлөлт зарим хэсэгт өсөлт, эерэг нөлөө дагуулж байна

Г.Байгал
@baigalZGM

А л т а н нар, шаргал элсээр алдартай Калифорнийн зун. Жил бүрийн долдугаар сард дал модны зурагтай цамцаар гоёж, далайн эрэг дээр биеэ наранд шарж хэвтдэг зарим америк хүн энэ зуныг Хойд Америкийн цанын баазуудад цана, чаргаар гулгасан шиг өнгөрөөж байна. Урин дулаантай уралдан үүдээ барьж, үйл ажиллагаагаа зогсоодог Америкийн цанын баазууд энэ зун амрах завгүй, ачаалалтай ажиллах болжээ. 8.4 тэрбум ам.доллараар хэмжигдэх, Хойд Америкийн цанын баазын бизнест уур амьсгалын өөрчлөлт эергээр нөлөөлж, идэвхтэй ажиллах өдрийн тоог нэмэгдүүлж, энэ хэрээр ахиу орлого олох боломжийг нээсэн нь энэ.

Туйлын цаг уурын өөрчлөлт энэ бүс нутагт орох хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж, агаарын хэвийг буулгасан байна. Мөн энэ жил агаарын хэм олон жилийн дунджаас сэрүүн байснаар цаг наашилсан ч цас хайлсангүй өдий хүрээд буй юм. Өвлийн хэдхэн сараар үйл ажиллагаа нь хэмжигддэг байсан цанын баазуудын ажиллах хугацаа сунаснаар Vail амралтын

баазын гулгачдын тоо 20 хувиар өсөж, 13.7 саяд хүрсэн бол орлого нь 20 хувиар дээшилж, 1.8 тэрбум ам.доллартай тэнцжээ.

Уур амьсгалын өөрчлөлт бол хүн төрөлхтний өмнө тулгарч буй хамгийн том сорилтын нэг. Энэ аюул хүн төрөлхтний бахархал, хөгжил дэвшлийн гэрч болсон бүтээн байгуулалтыг хормын төдийд нурааж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, экологийн доройтол, сүйрлийн бараан мэдээ дэлхий дахинд тасралтгүй хөвөрсөөр байна.

Гэхдээ хар бараан мэдээ, хор хохиролтой зэрэгцээд цаг уурын өөрчлөлт дэлхийн зарим хэсэгт өсөлт, эерэг нөлөө дагуулж буй нь ажиглагдаж эхэллээ. Зөвхөн Америк гэлтгүй Альпийн нуруу орчмын аялал жуулчлалыг ч дэлхийн дулаарлаас үүдсэн өөрчлөлт хөгжүүлж байгаа аж. Далайн түвшнээс дээш, өндөрлөг

хэсэгт о р ш д о г энэ нутаг зуны улиралд хүйтэн, чийглэг уур амьсгалтай тул жуулчдад тааламжтай хэсэгт тооцогддоггүй. Харин сүүлийн жилүүдэд цаг уур алгуур дулаарч буйгаас Альпийн нуруу зуны цагт жуулчдыг соронз мэт татдаг газар болох төлөвтэй. Энэ хандлага Ботсванад ажиглагдаж, цаг уурын дулаарал аялахад улам тааламжтай болгосноор тус улсыг чиглэх жуулчдын тоо нэмэгдэж байгаа аж.

Аялал жуулчлал зэрэг зарим салбарт гарч буй өсөлтийг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гарз, хохиролтой

харьцуулшгүй. Гэхдээ дэлхийн дулаарлаас үүдсэн айдас, заналхийлэл дунд зарим эерэг тал ажиглагдаж байгаа нь энэ. Ер нь дэлхий дахинд далайн эрэг дээр хэвтэх өдрүүдийн тоо нэмэгдэж, үйлчилгээний салбар өргөжин тэлэх төлөвтэй. Ирэх арван жилд аялал жуулчлалын салбарт цаг уурын өөрчлөлт үл мэдэг мэдрэгдэнэ. Харин дунд хугацаанд илт мэдрэгдэж, дэлхийн жуулчдын урсгалыг ч цаг уурын өөрчлөлт эргүүлж мэдэх нь. Ялангуяа, хүйтэн бүс нутгуудын цаг уур бүлээсэж, эрс тэс цаг уурыг илүү тааламжтай болгосноор эдүгээ халуун дулаан орныг чиглэж буй жуулчдын урсгал эргэж, сэрүүн орнуудыг зүглэх таамаглал ч байна.

Тэгвэл Монголд хэрхэн нөлөөлөх бол. Энэ асуултад олон улсын судлаачид хуваагдмал байр суурь илэрхийлдэг. Цаг уурын өөрчлөлт нь цөлжилт хуурайшилт, ган, зуд зэрэг байгалийн гамшиг дагуулж, малчдын амьжиргаа, хүнс хөдөө аж ахуйн салбарыг сөхрүүлэх эрсдэл бийг зарим судлаач анхааруулж буй.

Гэхдээ Азийн хөгжлийн банкаас танилцуулсан дэлхийн дулаарлаас урт хугацаанд эдийн засгийн хэмнэлт, эерэг нөлөө хүртэх боломжтой орнуудын тоонд Монгол Улс бичигдэж



байгаа. Цаг агаар дулаарснаар манай улсын ДНБ-ий өсөлт 1.4 хувиар эрчимжих тооцоо бий. Мөн АНУ-ын Sussex их сургуулийн эрдэмтний тооцоогоор дэлхийн дулаарлаас үүдэн жуулчдын тоо нь өсөх орнуудын жагсаалтад Монгол Улс хоёрдугаарт бичигдсэн. Монголыг чиглэх жуулчдын тоо дэлхийн дулаарлаас үүдэн дунд хугацаанд 122 хүртэл хувиар нэмэгдэх төлөвтэй аж.





Уг нийтлэлээр уур амьсгалын өөрчлөлтийг өмөөрч, хөхүүлэн дэмжихийг зорьсонгүй. Харин саарын хажуугаар сайн гэгчээр шинэ тутам ажиглагдаж буй шинэ зүйлийг өгүүлэхийг хичээсэн болно. Дэлхий нийтийн сорилт болж буй уур амьсгалын өөрчлөлтийн өмнө хүн төрөлхтөн хүчин мөхөсдсөөр буй. Гэхдээ энэ өөрчлөлтөөс бид бултаа аргагүй.

Бас гараа хумхин харсаар суугаад эх дэлхийгээ сүйрүүлж болохгүй. Иймд өмнөх алдаагаа үл давтаж, тогтвортой хөгжлийн төлөө хүчин зүтгэхийн сацуу уур амьсгалын сайн, муу сүлэлдсэн өөрчлөлтийг соргогоор мэдэрч, бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах ажил ч биднийг хүлээж байна. Ялангуяа, цаг уурын эрс тэс уур амьсгал монголчуудад эдийн засгийн сул тал болдог нь үнэн. Гэхдээ энэ сул талыг бүдгэрүүлж, зарим талаар эдийн засгийн хэмнэлт, өсөлт авчрах боломжийг байгаль орчны өөрчлөлт олгож байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс айж суусаар хохирох бус харин байгаль орчин, нийгэм, эдийн засагт ажиглагдаж буй шинэ зүйлийг соргогоор мэдэрч, тохирсон бодлого хэрэгжүүлж чадвал эрсдэлийг ч өөртөө ашигтайгаар эргүүлж болох нь. [ZGM]



Цаг агаар дулаарснаар манай улсын ДНБ-ий өсөлт 1.4 хувиар эрчимжих тооцоотой.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES 0.13%	S&P 500 0.13%	FTSE 100 0.23%	NIKKEI 225 0.09%	TOPIX 0.12%	SHANGHAI COMPOSITE 0.24%	HANG SENG 0.39%	KOSPI 0.03%
---------------------------	-----------------------------	--------------------------	----------------------------	-----------------------	------------------------------------	---------------------------	-----------------------